



ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК

“2018 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН”

Дархан-Уул аймаг

2018 он

АГУУЛГА

Компанийн товч танилцуулга

Нэг. Үйлдвэрлэлийн үзүүлэлт

- 1.1. Цахилгаан эрчим хүчний түгээлт
- 1.2. Дамжуулалт түгээлтийн алдагдал

Хоёр. Эдийн засгийн үзүүлэлт

- 2.1. Нийт зардал
- 2.2. Тогтмол зардал
- 2.3. Ашиг /алдагдал/
- 2.4. Богино хугацаат авлага /өглөг/
- 2.5. Сэлбэг материалын үлдэгдлийн бууралт
- 2.6. 2016 оны борлуулалт, орлого цуглуулалт

Гурав. Технологийн сахилга

- 3.1. Үйлдвэрлэлийн осол аваарь, саатал
- 3.2. Ашиглалтын жигд ажиллагаа, горимын зөрчил
- 3.3. Тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга, үзлэг шалгалтын графикийн биелэлт

Дөрөв. Техникийн бодлого

- 4.1. Өвлийн бэлтгэл ажлын биелэлт
- 4.2. Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт

Тав. Хамт олны оюуны чадавхийн үнэлэмж


- 5.1. Техник технологийн шинэчлэлт /иноваци/

Зургаа. Үзлэгийн дүн

- 6.1. Хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт
- 6.2. Хөдөлмөр Хамгаалал Аюулгүй Ажиллагаа, ГАУС ажлын биелэлт
- 6.3. Ажлын байрны эмх цэгц
- 6.4. Техникийн бичиг баримтын хөтлөлт
- 6.5. Байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлууд

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн дагуу Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК нь Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудын 26 сумын 74000 км² нутаг дэвсгэрт орших 4435 аж ахуйн нэгж, 44491 айл өрх, нийт 48926 хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч түгээх, хангах үйл ажиллагааг Монгол Улсын Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Улсын Стандартчилал Хэмжилзүйн Төвөөс олгосон 10 тусгай зөвшөөрөл, лицензийн дагуу явуулж байна.



Үүнд:

- 1) Цахилгаан түгээх
- 2) Цахилгаанаар зохицуулалттай хангах
- 3) 5-100 МВт-ын эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах
- 4) 0.4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар
- 5) Туршилт тохируулгын ажил үйлчилгээ /2-догч коммутацийн ажлууд болон хэмжилт туршилт тохируулгын бүх төрлийн ажлууд/
- 6) Бусад дагалдах ажил үйлчилгээ /өрлөг дулаалга бэхэлгээ болон тулгуур хийц хэсгийн үйлдвэрлэлт, нийлүүлэлт/
- 7) 0.1-100МВт-ын эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах
- 8) Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 110кВ-оос дээш
- 9) ЦЭХ-ний 1 ба 3 фазын тоолуурын шалгалт, тохируулга, суурилуулах
- 10) Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих





Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйл

Уриа - ГЭРЛИЙН ХУРДААР ХӨГЖЛИЙГ ДЭМЖИНЭ...

Алсын хараа- Эрчим хүчийг дэвшилтэт технологиор хэрэглэгчдэд....

Эрхэм зорилго- Чадварлаг хүний нөөцөд тулгуурлан аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэвшилтэт технологийн нэвтрүүлэн, хэрэглэгчээ дээдэлсэн, салбартаа тэргүүлэгч үйлчилгээний байгууллага болно.

Үнэт зүйл - Дэвшилтэт технологи, Сэтгэл зүтгэл, Цогц чадамж, Төгөлдөршил, Сахилга бат, Хэрэглэгчийн итгэл, Компанийн засаглал


Тэргүүлэх чиглэл – Техник технологи, Хүний нөөц, Хөгжил, Өсөлт, Аюулгүй ажиллагаа, Хэрэглэгч

Үндсэн зорилт:

- 1) Дэлхийн жишигт хүрсэн техник, технологи, IT программ хангамжийг ашиглаж, хөгжүүлнэ.
- 2) Санал санаачлагатай, өөриймсөг, бүтээлч шийдэлтэй нэгдмэл чадварлаг сэтгэл зүтгэлтэй хамт олон байна.
- 3) Дэвшилтэт технологи, чадварлаг хүний нөөцтэй хэрэглэгчдийнхээ хүсэлт тэмүүллийг мэдэрдэг, өндөр бүтээмж цогц чадамжтай компани болно.
- 4) Бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд осол аюулгүй, түргэн шуурхай хүргэж, борлуулалтын орлого, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлнэ.
- 5) Аюул, эрсдэлийг илрүүлж,арилган аюул эрсдлээс сэргийлэх зөв дадал хэвшил эзэмшүүлж, осол зөрчилгүй ажиллана.
- 6) Харилцагч, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлж, харилцан итгэлцэл, хүндлэлийг бий болгон ажиллана.
- 7) Бид ирээдүй болон цаашдын хөгжил дэвшилд бодлогыг тодорхойлж,ажилтан албан хаагчийн эрх ашгийг дээдэлсэн, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлага ухамсарласан компани байна.

Зохион байгуулалтын бүтэц, хүний нөөц

Бодлого зохицуулалтын 5 хэлтэс, мэдээлэл технологи, шуурхай удирдлага, засвар туршилт, хэмжүүр тоолуур, тээвэр үйлчилгээний чиглэлээр ажиллах 5 алба, тоног төхөөрөмжийн ашиглалт борлуулалтын ажлыг эрхлэн гүйцэтгэх 4 салбар, 2 төвтэйгээр нийт 442 ажилтан ажиллалаа.



Нийт 442 ажилтны 298 буюу 67.4 хувийг эрэгтэйчүүд, 144 буюу 32,6 хувийг эмэгтэйчүүд тус тус эзэлж байна. Үүнээс 53 буюу нийт эмэгтэйчүүдийн 36,8 хувийг 40-өөс дээш насны эмэгтэй, өрх толгойлсон эмэгтэй 15, хөгжлийн бэрхшээлтэй 2 эмэгтэй ажилтан байна.




Нийт ажилтнуудын 36 хүртэлх насны 268 ажилтан буюу 60.6 хувь, 36-аас дээш насныхан 174 ажилтан буюу 39,4 хувийг тус тус эзэлж байна.



Компанийн ажилтнуудын дундаж нас 35 байна.

Удирдах болон болон ИТА 141, бага тушаалын болон мэргэжилтэй 301 ажилтнууд ажиллаж байна. Эрчим хүчний зөвлөх инженер 3, мэргэшсэн инженер 2, мэргэшсэн төсөвчин 1, мэргэшсэн ня-бо 1 гэсэн мэргэшлийн зэрэгтэй ажилтнууд байна.



Нийт ажилтнуудын 222 ажилтан буюу 50,2 хувийг дээд боловсролтой, 57 ажилтан буюу 12,9 хувийг тусгай дунд боловсролтой, 149 ажилтан буюу 33,7 хувийг бүрэн дунд боловсролтой, 14 ажилтан буюу 3,2 хувийг бүрэн бус дунд боловсролтой ажилтнууд тус тус эзэлж байна. Үүнээс 22 магистр зэрэгтэй ажилтнууд, 16 ажилтан гадаадад мэргэжил, боловсрол эзэмшсэн байна.




НЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ДСЦТС ХК нь 2018 онд “Хэрэглэгчдийг найдвартай эрчим хүчээр хангах” уриа дэвшүүлэн борлуулалтын үндсэн үзүүлэлтүүд болох “Нэг худалдан авагч”-аас худалдаж авах цахилгаан эрчим хүчний хэмжээг бууруулахгүй, Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос баталсан төлөвлөгөөт алдагдлыг бууруулж, борлуулалт, орлого төвлөрүүлэлтийг өсгөх, хэрэглэгчдээс авах авлагыг бууруулах зорилттой ажиллалаа.

Хэрэглэгчийн бүтэц

Хэрэглэгч	Дархан-Уул	Сэлэнгэ	Төв	Бүгд
ААН	2,197	1,142	479	3,818
Төсөв	280	294	43	617
Орон сууц	13,387	3,003	8	16,398
Гэр хороолол	10,837	13,898	3,358	28,093
Дүн	26,701	18,337	3,888	48,926
Эзлэх хувь	55%	37%	8%	100%


Хэрэглэгчийн бүтэц



1.1. Цахилгаан эрчим хүчний түгээлт

2018 онд нэг худалдан авагчаас 443.6 сая кВт цаг цахилгаан эрчим хүч /ЦЭХ/ худалдан авахаар төлөвлөснөөс 437.4 сая кВт цаг ЦЭХ авч 6.2 сая кВт цагаар буурсан боловч Аж ахуйн харилцааны дүрэмд заасан хэмжээнд буюу 1,4% байна.

ЦЭХ-ний түгээлт /сая.кВт.цаг/



1.2. Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал

Компанийн дүнгээр цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал 61,2 сая кВт цаг буюу 13,98 хувь болж төлөвлөгөөт 14,80 хувийн алдагдлаас 0.82 пунктээр бууруулж, Эрчим хүчний Зохицуулах хорооноос баталж өгсөн зорилтыг хангасан.

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2018 оны төлөвлөгөө	2018 оны ХБГ	Өсөлт +/-,
				бууралт +/-
Худалдаж авсан ЦЭХ	сая кВт ц	443.6	437.4	-6.2
Түгээлтийн алдагдал	биет	65.6	61.1	-4.5
	хувь	14.80%	13.98%	-0.82%
Борлуулсан ЦЭХ	сая кВт ц	378	376.2	-1.8

Сүүлийн 4 жилээр ЦЭХ-ний нийт түгээлтийн алдагдлыг хүчдлийн түвшингээр нь ангилж харуулбал компанийн өөрийн 35/6/0,4 кВ-ын сүлжээний алдагдал 20,56%-20,52% болж 0,04 пунктээр, 2018 онд 0,01 пунктээр буурлаа.

ЦЭХ-НИЙ ТҮГЭЭЛТИЙН АЛДАГДАЛ



Тус компани нь 2018 оны ХБГ-ээр 437,4 сая.кВт.ц ЦЭХ-ийг худалдан авч 13.98 хувийг цахилгаан түгээлтийн алдагдалд зарцуулж, хэрэглэгчдэд 376,2 сая.кВт.ц ЦЭХ-ийг түгээн борлуулсан байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Тус компани нь 2018 оны ХБГ – ээр 437.41 сая.кВт.ц ЦЭХ-ийг худалдан авч 13.98 хувийг цахилгаан түгээлтийн алдагдалд зарцуулж, хэрэглэгчдэд 376.3 сая.кВт.ц ЦЭХ-ийг түгээн борлуулсан байна.

Тайлант онд нийт 74998.9 сая төгрөгийн орлоготой, 74586.7 сая төгрөгийн зардал гарган ажилласнаар 2018 оны ХБГ – ээр 412.2 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллалаа.

д/д	Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2016 он гүйцэтгэл	2017 он гүйцэтгэл	2018 он ХБГ	Өмнөх онтой харьцуулахад	
						биет	хувь
1	Худалдаж авсан цахилгаан	сая.кВтц	402.7	427.20	437.41	10.21	2.4%
2	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал: хувиар	хувь	14.20%	13.65%	13.98%	0.00	
	биетээр	сая.кВтц	57.2	58.3	61.1	2.80	4.8%
3	Борлуулах цахилгаан эрчим хүч	сая.кВтц	345.5	368.9	376.3	7.42	2.0%
4	Нийт орлого	сая.төг	48740.5	70702.0	74998.9	4296.90	6.1%
	Борлуулалтын орлого	сая.төг	48321.0	54179.6	57031.5	2851.90	5.3%
	Түгээх үйлчилгээний орлого	сая.төг	0.0	15189.2	16640.5	1451.30	9.6%
	Үйл ажиллагааны бусад орлого	сая.төг	419.5	1333.2	1326.9	-6.30	-0.5%
5	Нийт зардал	сая.төг	47352.2	68140.7	74586.7	6446.00	9.5%
	Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төг	17483.8	17470.1	18300.3	830.20	4.8%
	ХАЦЭХ-ний төлбөр	сая.төг	29472.6	49894.6	55295.8	5401.20	10.8%
	Үйл ажиллагааны бусад зардал	сая.төг	395.8	776.0	990.6	214.60	27.7%
6	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	1388.3	2561.3	412.2		
7	Нийт авлага	сая.төг	2827.2	2461.9	2235.0	-226.90	-9.2%
	Үүнээс: цахилгааны авлага	сая.төг	1700.9	1269.7	1028.0	-241.70	-19.0%
8	Нийт ер төлбөр	сая.төг	1650.5	4115.3	3636.5	-478.80	-11.6%
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая.төг	1617.9	4084.9	3606.1	-478.80	-11.7%
9	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	6524.9	8590.8	4882.7	-3708.08	-43.2%
10	Нийт ажиллагсдын тоо	тоо	429	433.0	442	9.00	2.1%
11	Нийт цалингийн сан	сая.төг	5852.4	5857.1	6758.3	901.20	15.4%

2.1. НИЙТ ЗАРДАЛ

Тус компани нь 2018 оны ХБГ-ээр 74.5 тэрбум төгрөгийн нийт зардалтай ажиллахаар байна.

№	Үзүүлэлт	Хэм.нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 оны төлөвлөгөө	2018 оны ХБГ
1	Нийт зардал	сая.төг	67250.1	72238.8	74586.7
2	Үүнээс: ЦЭХ-ний төлбөр	сая.төг	48599.4	51491.7	55295.8
3	Үйл ажиллагааны зардал	сая.төг	17995.4	20352.1	18300.3
4	Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	655.3	395	990.6





2.2. ТОГТМОЛ ЗАРДАЛ

2018 оны ХБГ–ээр өөрийн үйл ажиллагааны тогтмол зардалд 4725.9 сая төгрөг зарцуулахаар байна. 2018 оны зорилтот түвшинтэй харьцуулахад 590.7 сая төгрөгөөр буюу 14%-иар тогтмол зардал өссөн.


Д/д	Зардлын төрлүүд	2018 оны тарифт туссан	2018 оны ХБГ	Өөрчлөлт Тарифт туссанаас
1	Шатахууны зардал	237,738.7	308,694.6	70,955.9
2	Тээврийн зардал	12,740.0	5,363.2	(7,376.8)
3	Сэлбэг хэрэгсэл	52,338.2	100,339.9	48,001.7
4	Урсгал засвар	1,420,514.9	1,662,761.1	242,246.2
5	Материал, хангамжийн материал	16,075.3	72,382.9	56,307.6
8	Ашиглалтын зардал-Цахилгаан	296,037.8	297,023.2	985.4
9	Ашиглалтын зардал-Дулаан	62,234.2	69,351.0	7,116.8
10	Ашиглалтын зардал-Ус	35,823.6	44,044.6	8,221.0
11	Албан томилолтын зардал	91,524.9	117,856.4	26,331.5
12	Конторын хангамжийн зардал	18,409.9	29,979.8	11,569.9
13	Харилцаа холбоо, бичиг хэргийн зардал	132,190.1	173,235.2	41,045.1
14	Харуул хамгаалалтын зардал	86,400.0	86,400.0	-
15	Хөдөлмөр хамгааллын зардал	287,344.4	292,249.4	4,905.0
16	Даатгалын зардал	8,100.3	7,597.9	(502.4)
17	Галын аюулаас хамгаалах зардал	2,110.0	40,115.9	38,005.9
18	Гүйцэтгэх удирдлагын зардал	65,679.1	65,680.4	1.3
19	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	107,911.2	77,550.0	(30,361.2)
21	Борлуулалт, маркетингийн зардал	24,879.0	29,863.0	4,984.0
22	Диспетчерийн зардал	306,802.8	337,291.5	30,488.7
23	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	73,512.0	73,512.0	-
24	Гадны үйлчилгээний хөлс	46,202.3	53,064.0	6,861.7
25	Түрээсийн зардал	12,515.6	7,443.9	(5,071.7)
26	Сургалтын зардал	61,852.1	66,256.3	4,404.2
28	Үйл ажиллагааны бусад зардал	65,597.4	65,594.0	(3.4)
31	Үл хөдлөх хөрөнгийн татвар	77,545.6	77,545.6	0.0
32	АТӨЯХ-ийн албан татвар	5,374.1	8,676.2	3,302.1
33	Газрын төлбөр	16,359.5	16,359.5	0.0
35	Ажиллагсдын нийгмийн зардал	511,369.0	539,668.6	28,299.6
Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ		4,135,181.9	4,725,900.0	590,718.0



2.3. АШИГ /АЛДАГДАЛ/

2018 оны ХБГ–ээр үндсэн үйл ажиллагаанаас 75.9 сая төгрөгийн ашигтай, үндсэн бус үйл ажиллагаанаас 336.3 сая төгрөгийн ашигтай ажиллаж балансын дүнгээр 412.2 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллаж зорилтот түвшинг хангаж ажиллалаа.

Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/ сая.төг



2.4. БОГИНО ХУГАЦААТ АВЛАГА, ӨГЛӨГ

2.4.1. Богино хугацаат авлага

Авлaгыг өнгөрсөн оноос 226,9 сая төгрөгөөр буюу 9,2%-иар бууруулж, зорилтот түвшинг хангаж ажиллалаа.

Авлага /сая.төг/





2.4.2.Богино хугацаат өглөг

Нийт өглөгийг оны эхнээс 478.8 сая төгрөгөөр буюу 13%-иар бууруулж ажиллалаа.

№	Ангилал	2018 оны эхний үлдэгдэл	2018 оны ХБГ	Өөрчлөлт	
				Оны эхнээс	Хувь
1	Нэг худалдан авагч	939.1	1420.0	480.9	51%
2	Татварын өглөг	213.0	135.0	-78	-37%
3	Бусад богино хугацаат өглөг	2526.7	1645.0	-881.7	-35%
Нийт өглөгийн дүн		3678.8	3200.0	-478.8	-13%

Диспетчерийн Үндэсний Төв ХХК-д төлөх өглөг оны эхнээс 480,9 сая төгрөгөөр өсч, бусад богино хугацаат өглөг оны эхнээс 881,7 сая төгрөгөөр буурлаа.

2.5.СЭЛБЭГ МАТЕРИАЛЫН ҮЛДЭГДЛИЙН БУУРАЛТ

2018 оны 11 сарын байдлаар сэлбэг материалын үлдэгдэл оны эхнээс 1438,79 сая төгрөгөөр буюу 33%-иар буурсан.

Агуулахад байгаа бараа материалын үлдэгдлийг өмнөх онтой харьцуулан гаргавал:




№	Төрөл	Оны эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт
1	Цахилгаан сэлбэг хэрэгсэл	4231.06	2767,96	-34.5
2	Аварийн нөөц	23,9	12,4	-48.1
3	Шатахуун ба шингэн түлш	1.48	6,04	308
4	Тосолгооны материал	6.5	5,8	-10.7
5	Тээврийн сэлбэг хэрэгсэл	12.5	13,2	5.6
6	Хангамжийн материал	61.13	58,7	-3.9
7	Хөдөлмөр хамгаалал хувцас хэрэгсэл	22.49	56,07	149
	ДҮН	4359,09	2920,3	-33

2.6. ТУХАЙН ОНЫ БОРЛУУЛАЛТ, ОРЛОГО ЦУГЛУУЛАЛТ

2018 оны ХБГ-ээр нийт 56,9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 57,1 тэрбум төгрөгийн орлого цуглуулж орлогын 100,2% -ийн гүйцэтгэлтэй байна.



ГНОТ, цуглуулсан орлого





ГУРАВ. ТЕХНОЛОГИЙН САХИЛГА

3.1.ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ

2018 онд ДСЦТС ХК нь үйлдвэрлэлийн осол гаргалгүй ажиллалаа.

ДСЦТС ХК нь аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх залруулах, аюул, эрсдэлгүй ажлын байр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог сайжруулах, осол зөрчилгүй ажиллах зорилгоор **ISO-45001** ХЭМАБ-ын олон улсын удирдлагын системийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Стандартын хүрээнд:

1. ХЭМАБ-ын бодлого, зорилго, хөтөлбөр
2. 214 үйл явцын эрсдлийн үнэлгээ
3. 120 зааврыг шинэчилж боловсуулж бүртгэсэн
4. Гамшгаас хамгаалах,онцгой байдалд хариу арга хэмжээ үзүүлэх төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан
5. Эрсдлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.аюулгүй ажиллагааны зааврууд боловсруулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, ААД, ТАД-ийн шаардлагуудыг хангаж ажиллах хүрээнд:

2018 онд компанийн хэмжээнд хийгдэх **6313** захиалгат ажлыг хянаж, нарыдаар **2680**, шийдвэрээр **3633** гүйцэтгэх ажлын захиалга, зааварчилгаа, бригадыг хянаж ажилласан байна.

ХАБЭА-н анхан шатны үзлэгийг **5012**, II шатны үзлэгийг **533** нийт **5545** үзлэгийг хийж Салбар, төв, алба нь журмын дагуу зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан.

ХАБЭА-н хяналтын үзлэгүүдээр шугам, тоноглол, дэд станц, ХБ, ТП-нүүдийн диспетчерийн нэр хаяг, урьдчилан сэргийлэх плакат тэмдгийн байдалд үзлэгийг хийж байгаа ба тухай бүр үүрэг даалгавар өгч зөрчлийг арилгуулж байна. Үзлэгийн мөрөөр зохиосон ажлуудыг хүснэгтээр харуулбал:

д/д	Хийгдсэн ажил	2018 он
1	Шинэчилсэн аюулгүй ажиллагааны плакат	4748



3	АШ тулгуур дугаарласан сэргээсэн	2965
4	Дэд станц ХБ нэр хаяг сэргээсэн	912
5	Шинээр цоож цүү хийсэн	1468
6	Шинээр болон давтан газардуулга хийсэн тоо	478

Аюулгүй ажиллагааны плакат тэмдэг, диспетчерийн нэр хаяг сэргээсэн байдлыг салбар хэсэг нэгжээр харуулбал:

Д/Д	Салбар нэгжийн нэр	Шинэчилсэн аюулгүй ажиллагааны плакатны тоо	Диспетчерийн нэр хаяг сэргээсэн дэд станцын тоо
1	Сүхбаатар салбар	449	31
2	Зүүнхараа салбар	1036	669
3	Жаргалант салбар	79	11
4	Хөтөл салбар	220	8
5	ЗТТА	642	3
6	ШҮМА	132	12
7	ДХҮТ ерөнхий шит	1335	
8	ДТТ	1444	68
	НИЙТ ДҮН	5337	802

Компанийн хэмжээнд салбар алба төв ажилтнуудаа давхардсан тоогоор **52825** удаа анхан шатны, өдөр тутмын давтан зааварчилгаа, сарын давтан зааварчилгаа, ээлжит бус зааварчилгаа, тухайлсан зааварчилгаануудад хамруулсан.

2018 оны ээлжит сургалтыг зохион байгуулж 319 ажилтнаас ээлжит шалгалтыг авч 317 ажилтан тэнцэж, 2 ажилтан тэнцээгүй, шинээр 11 ажилтан орж шалгалтанд орсон байна.

Ажлын байран дээрх сургалтын хөтөлбөр, Дагалдан сургалтын хөтөлбөр, Нийтлэг ажилтны сургалтын хөтөлбөр, Схем тоноглолын сургалтын хөтөлбөр, Тусгай бэлтгэлийн ажилтнуудын сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтын хөтөлбөрүүд боловсруулж ажилласан .



✚ 2018.04.12-ны өдөр Дархан-Уул аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоо, ДСЦТС ХК-ний үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран шинээр ажилд орсон 12 ажилтанд 8 цагийн сургалт зохион байгуулсан.



✚ 2018.06.13-ний өдөр ХШААХ-тэй хамтран шинээр ажилд орсон 12 ажилтны сургалтыг Хөдөлмөр нийгэм хамгаалалын сайдын А/33 үлгэрчилсэн хөтөлбөрийн дагуу 8 цагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар хууль эрх зүй, ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, ГАУС, эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулсан.

✚ Дагалдан сургалтын хөтөлбөрийг тоолуур сүлжээний монтёр, тоолуурын заалт авагч, ашиглалт борлуулалтын байцаагч, авлага барагдуулагч, ашиглалт засварын монтёр, хуулийн зөвлөх, тооцооны техникч, горим тооцооны инженер гэсэн 8 албан тушаалын 14 ажилтанд боловсруулан гаргаж өгч ажилласан байна.



✚ 2018-03-14,15-ны өдрүүдэд НДУдам" ХХК-ийн сургалтын төвтэй хамтран Оосорлогч дохиочин, хяналт хариуцагч, кранистын эрх сунгах, аюулгүй ажиллагаа хариуцагчийн 16 цагийн сургалтыг 54 ажилтанд зохион байгуулан эрхийг баталгаажуулсан байна.

✚ 2018.06.13-нд шинээр ажилд орсон 12 ажилтанд анхны тусламжийн 2 цагийн сургалтыг нэгдсэн эмнэлэгийн гэмтлийн их эмч Э.Нямбаатар дадлага сургалт явуулсан.



✚ Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор тус зөвлөлийг эрх бүхий байгууллага болох ОШМИ сургалтын төвд мэргэшүүлэх сургалтанд хамруулан сургасан

✚ 2018.01.24,25-ны өдрүүдэд ДХҮТ, компанийн инженер техникийн ажилтнуудад эрүүл мэндийн үзлэгийн өмнөх урьдчилан сэргийлэх сургалтыг эрүүл



мэндийн газартай хамтран халдварт бус өвчлөл, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай сургалтыг зохион байгуулсан. 114 ажилтан хамрагдсан.

✚ **2018-02-08**нд шинээр ажилд орсон 20 ажилтанд анхны тусламжийн 1.30 минутын сургалтыг нэгдсэн эмнэлэгийн яаралтай тусламж 103-ын ахлах эмч Э.Хишигсүрэн дадлага сургалт явуулсан.

✚ **2018.06.13-нд** шинээр ажилд орсон 12 ажилтанд анхны тусламжийн 1.30 минутын сургалтыг нэгдсэн эмнэлгийн гэмтлийн их эмч Э.Нямбаатар дадлага сургалт явуулсан.

Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015, ISO45001:2018 ХЭМАБ-ын тогтолцоог нэвтрүүлэх сургалт

Д/д	Сургалтын нэр	Сургалт явуулсан хугацаа	Сургалтанд хамрагдсан салбар, нэгж /албан тушаал/	Сургалтанд суусан хүний тоо
1	ISO9001:2015 танилцуулах сургалт	2018.03.15	Төслийн баг	26
2	Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015, ISO45001:2018 ХЭМАБ-ын стандартын танилцуулах сургалт	2018.03-04 сард	Компанийн нийт нэгж	300
3	Байгууллагын гадаад дотоод орчны шинжилгээ хийх сургалт	2018.03.16	Төслийн баг	29
4	Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015, ISO45001:2018 ХЭМАБ-ын стандартын шаардлага	2018.03.16	Төслийн баг	22
5	Баримт бичгийн удирдлага	2018.03.26	Салбар нэгжийн дарга ИТА	37
6	Баримт бичгийн удирдлага, сэтгэл зүйн үнэлгээний үр дүн, Байгууллагын орчин, сонирхогч талуудын шинжилгээ	2018.03.31	Төслийн багийн хэсэг ажилтнууд	12
7	Компанийн үйл явцийн зураглал боловсруулах	2018.04.10	Салбар нэгжийн дарга, мастер Төслийн баг	36
8	Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015, ISO45001:2018 ХЭМАБ-ын стандартын сургалт	2018.04.20	ТУЗ-ийн гишүүд	8
9	Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015, ISO45001:2018 ХЭМАБ-ын стандартын танилцуулах сургалт	2018.05.01	Жаргалант салбар	24
10	Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015, ISO45001:2018 ХЭМАБ-ын	2018.05.02	Сүхбаатар салбар	29



	стандартын танилцуулах сургалт			
11	Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015, ISO45001:2018 ХЭМАБ-ын танилцуулах сургалт	2018.05.04	Зүүнхараа салбар	35
12	Эрсдэлийн менежмент хуулийн нийцлийн үнэлгээ	2018.05.11	Салбар нэгжийн удирдлага, ИТА	35
13	Бичиг баримтын хяналтын журам, Архив, албан хэрэг хөтлөлтийн журам	2018.05.11	Нэгжийн удирдлагуудад	20
14	5s Ажлын байрны эмх цэгц	2018.06.11	Төслийн баг	25
15	Чанар (ISO9001:2015), ХАБЭА-н (ISO45001:2018) Удирдлагын тогтолцооны хамрах хүрээг тодорхойлох, бодлого боловсруулах	2018.06.15	Төслийн баг	11
16	ISO9001:2015, ISO45001:2018 танилцуулах сургалт /гадаад зөвлөх багш/	2018.11.07	Нэгжийн удирдлага ажилтнууд	45
17	Дотоод аудитын сургалт	2018.11.14, 15	Нэгжийн удирдлага, ажилтнууд	45
	Нийт 17 удаа			778 ажилтан

Эрчим хүчний яамнаас шуурхай ажиллагаа, шуурхай үйлчилгээ засварын ажилтан нарт Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм, Нэгдсэн сүлжээний дүрэм, Нэгдсэн сүлжээнд гарсан аваари устгах болон цахилгааны хуваарилах байгууламжид сэлгэн залгалт хийх заавруудаар шалгалтын комисс болон шуурхай ажиллагаа, шуурхай үйлчилгээ засварын 61 ажилтнаас шалгалт авснаас 10 ажилтан 100%, 12 ажилтан 90% хувийн амжилт үзүүлж, компанийн шалгалтын дүн 89.2%-ийн амжилттай дүгнэгдсэн.

2018 оны жилийн эцсийн байдлаар компанийн хэмжээнд Аюулыг мэдээлэх хуудсаар 178 мэдээлэл ирснээс Бага аюултай-17, их аюултай-63, ноцтой-28, дунд-12 аюул мэдээлэх хуудсаар ирсэн бөгөөд илэрсэн аюулуудыг устгаж, **“НЭН ТҮРҮҮНД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ”** зарчимд тулгуурлан осол зөрчилгүй ажиллалаа.



АВААРЬ, СААТАЛ

ДСЦТС ХК нь 2017 онд 10(6)кВ-ын сүлжээнд 148, 35кВ-н сүлжээнд 28 удаагийн тасралт гэмтэл гарч байсан бол 2018 онд 10(6)кВ-ын сүлжээнд 81, 35кВ-ын сүлжээнд 12 удаагийн тасралт тус тус гарсан байна.

2017, 2018 оны гэмтэл саатлыг дараах хүснэгтээр үзүүлэв


Д/д	2017 онд		2018 онд	
	35кВ-ын сүлжээнд	10(6)кВ-ын сүлжээнд	35кВ-ын сүлжээнд	10(6)кВ-ын сүлжээнд
1	148	28	81	12
Нийт	176		93	

35кВ болон 6(10)кВ-ын сүлжээний 2017, 2018 оны сүлжээний гэмтэл саатлыг харьцуулсан график




2017 онд нийт 47223,8 кВт*цаг цахилган эрчим хүчийн дутуу түгээж байсан бол 2018 онд 45196кВт*цаг цахилгаан эрчим хүчийг дутуу түгээсэн байна. Гэмтэл саатлын нийт үргэлжилсэн хугацаа нь 2017 онд 585,1 цаг байсан бол 2018 онд 229,58 цаг болж буурсан байна.

2017, 2018 оны гэмтэл саатлын үргэлжилсэн хугацааг дараах графикаар үзүүлэв



Дутуу түгээсэн цахилгаан эрчим хүчийг 2017, 2018 оноор харьцуулсан график



2018 онд гэмтэл саатлыг бууруулах чиглэлээр 2017 оны хамгийн их тасралттай шугам тоноглолын их болон урсгал засварын ажлыг чанартай хийж гүйцэтгэсэн. Мөн компанийн хэмжээнд ИТА-н ашиглалтын түвшин тогтоох үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж гэмтэл саатлаас урьдчилан сэргийлж ажилласан. Цаашид гэмтэл саатал гаргахгүй байх талаар болон урьд урьд гарч байсан гэмтэл саатлыг давтахгүй байх талаар ажилчдад тайлан сургалт зохион байгуулж 2019 оны их болон урсгал засварын ажлын хүрээнд шугам тоноглолын ашиглалт хэвийн ажиллагааг хангаж ажиллана.

3.2. АШИГЛАЛТЫН ЖИГД АЖИЛЛАГАА, ГОРИМЫН ЗӨРЧИЛ

Шугам тоноглолын ашиглалтын хэвийн ажиллагааг хангахын тулд 35/6(10) кВ-ын дэд станц, 6(10) кВ-ын хуваарилах байгууламж, 35кВ, 6-10кВ, 0,4кВ-ын агаарын болон кабель шугам, тоолуур төвлөрүүлсэн хайрцаг, орон сууцны ерөнхий болон давхрын шитүүдэд Техник ашиглалтын дүрэм, Ерөнхий инженерийн баталсан графикийн дагуу ээлжит эргүүл үзлэгийг тогтмол хийж, эргүүл үзлэгийн батлагдсан хуудасны дагуу үзлэг хийж буй ажилтанд даалгавар өгч илэрсэн

зөрчлийг тэмдэглүүлэн тухай бүр журналд тэмдэглэж гэмтэл зөрчлийг тогтмол устгаж болзошгүй аваари саатлаас урьдчилан сэргийлж ажилласан.

2018 онд компанийн хэмжээнд 8876 цэгт төлөвлөгөөт эргүүл үзлэг хийхээр төлөвлөөд хүлээгдэж буй гүйцэтгэлээр 8415 цэгт хийж 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 8415 удаагийн ээлжит эргүүл үзлэгээр 435 гэмтлийг илрүүлж устган 11,6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

2018 оны эргүүл үзлэгийг урьд онтой харьцуулвал:

№	Салбар нэгжийн нэр	2017 онд төлөвлөсөн	2017 оны гүйцэтгэл	2017 оны гүйцэтгэл /%/	2018 онд төлөвлөсөн	2018 оны ХБГүйцэтгэл	2018 оны ХБГүйцэтгэл /%/
	Дүн	6740	6740	100	8415	8415	100


2018 оны эргүүл үзлэгийг урьд онтой харьцуулбал



2017, 2018 онуудын үзлэгээр илрүүлсэн гэмтэл устгалтыг харьцуулбал

Д/д	Салбар хэсгийн нэр	Эргүүл үзлэгээр илэрсэн зөрчлийн тоо		Эргүүл үзлэгээр илэрсэн зөрчлийг устгасан тоо		Зөрчлийг устгасан хувь /%/	
		2017	2018	2017	2018	2017	2018
1	Дархан ТТөв	178	40	178	40	100	100
2	ДХУТөв	91	7	91	7	100	100
3	Сүхбаатар	483	133	458	133	94,8	100
4	Зүүн хараа	17	41	17	41	100	100
5	Хөтөл	398	77	372	77	93,4	100
6	Жаргалант	210	94	196	94	93,3	100
7	ЗТТАлба	26	5	23	5	88,4	100
8	ХТЛАлба	54	38	54	38	100	100
Нийт		1457	435	1389	435	95,3	100

2017, 2018 оны үзлэгээр илрүүлсэн гэмтлийг устгаж хэвийн ажиллагаанд оруулсан байдал



2018 онд үзлэгээр илрүүлсэн гэмтэл зөрчлийг 100% устгаж шугам тонололын хэвийн ажиллагааг ханган ажиллаж Улсын баяр болон ургац хураалтын үеэр томоохон аваари саатал гаргалгүй ажилласан.

Төлөвлөгөөт үзлэг шалгалтаас гадна Төлөвлөгөөт бус үзлэгийг баяр наадмын болон томоохон зохион байгуулалтын арга хэмжээ, өвлийн их ачааллын өмнө, шугам тоноглол реле хамгаалалтаар ажилласны дараа зэрэг ТАД-д заасны дагуу ээлжит бус үзлэг хийж ажилласан.

Гүйцэтгэх захирлын 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 87 дугаар тушаалаар батлагдсан удирдамж, хуваарийн дагуу ИТАжилтнуудын үзлэг, ХАБЭА-н гурван шатны хяналтыг *Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйг сайжруулах нэгдсэн журам*, Гүйцэтгэх захирлын 2018 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 125-р тушаалаар батлагдсан "Цахилгаан тоноглолын ашиглалтын түвшин тогтоох журам"-ын дагуу инженер техникийн ажилтнуудын үзлэгээр шугам тоноглолын **"АШИГЛАЛТЫН ТҮВШИН"** тогтоох ажлыг зохион байгуулсан.

Гүйцэтгэх захирлын 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 166 дугаар тушаалаар батлагдсан Ашиглалтын түвшин тогтоох журмын дагуу Ашиглалтын түвшинг байгууллагын хэмжээнд тоон үзүүлэлтээр дүгнэсэн.



"ДАРХАН-СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 166

Дархан

Журам батлах тухай

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйл, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт, Дэд бүтцийн сайдын 2003 оны 6 дугаар сарын 06-ны дрийн 125 тоот тушаалаар батлагдсан "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм", "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "ДСЦТС ХК-ийн цахилгаан тоноглолын ашиглалтын түвшин тогтоох журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, 6,10/0.4 кВ-ын агаарын дэд станц /АТП/-ыг түвшин тогтоох хуудсыг 2 дугаар хавсралтаар, 6,10/0.4 кВ-ын иж бүрдмэл дэд станц /КТП-Н/-ыг түвшин тогтоох хуудсыг 3 дугаар хавсралтаар, 6,10/0.4 кВ-ын хаалттай дэд станц /ТП/-ыг түвшин тогтоох хуудсыг 4 дүгээр хавсралтаар, 6, 10, 35 кВ-ын хуваарилах байгууламж /ЗРУ, КРУН, РП/-ыг түвшин тогтоох хуудсыг 5 дугаар хавсралтаар, 35/6, 10 кВ-ын дэд станцыг түвшин тогтоох хуудсыг 6 дугаар хавсралтаар, 0.4 кВ-ын агаарын шугамын ашиглалтын түвшин тогтоох хуудсыг 7 дугаар хавсралтаар, 6, 10 кВ-ын агаарын шугамын ашиглалтын түвшин тогтоох хуудсыг 8 дугаар хавсралтаар, 35 кВ-ын агаарын шугамын ашиглалтын түвшин тогтоох хуудсыг 9 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.


Хоёр. Компанийн хэмжээнд журмыг мөрдөж ажиллахыг хэлтэс, салбар, алба, төвийн дарга, ажилтнуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал бөгөөд Ерөнхий инженер /Б.Батжаргал/-т үүрэг болгосугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.НЭРГҮЙ

2017, 2018 оны ашиглалтын түвшинг харьцуулсан график



Компанийн хэмжээнд ашиглалтын түвшин



Цаашид ашиглалтын түвшин тогтоох үзлэгийг тогтмол хийж, салбар, нэгжийн шугам тоноглолын хэвийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, цаашид хийгдэх засварын ажлыг төлөвлөх, тулгамдсан асуудлыг газар дээр нь шийдвэрлэх, техникийн бодлого боловсруулах үндэслэл болгон ажиллах боломж бүрдсэн.

Графикийн дагуу хийгдэж байгаа ээлжит эргүүл үзлэг болон ээлжит бус эргүүл үзлэгийн хуудасны бичилт, хадгалалт, эргүүл үзлэгийн хуудасны дагуу илэрсэн гэмтэл зөрчлийг арилгах талаар хяналт тавьж ажиллахаас гадна 2016 онд шинээр хийсэн “ТЕХНИК АШИГЛАЛТ, БҮРТГЭЛ ТООЦООНЫ ПРОГРАМ”—д үзлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэл, илэрсэн зөрчлүүдийг оруулсанаар төрөл бүрийн судалгаа тооцоог хийж байна.

Горим ажиллагааны тухай

Горимын тооцоонд доорхи 4 төрлийн програм хангамжийг ашиглаж байна. Үүнд:

1. Горим тооцооны “Power factory 15.2” програмыг 2015 онд худалдан авч ашиглаж эхэлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар 35кВ-ын сүлжээний схем, бааз бүрдүүлэх ажлыг бүрэн хийснээр горимын бүх тооцоог хийж байна.



2. Доктор Ш.Гантөмөрийн бүтээсэн DLoss-0.4, DLoss-10 програмыг бүх салбар нэгжүүд ашиглан техникийн алдагдлыг тодорхойлж байна.

3. Диспетчерийн хяналтын системийг нэвтрүүлж дэд станц, хуваарилах байгууламжуудын таслуурын төлөв байдал, ажилласан хамгаалалтын төрөл, цахилгааны параметруудийг эгшин бүр авч тооцоонд ашиглаж байна.

4. Ухаалаг тоолуурын AMI системийг ашиглан баланс хийх, их ачааллын хэмжилт хийх, хоногийн ачааллын график, чадлын урсгал, хүчний трансформаторуудын ачааллыг хянадаг.

Дээрхи програм хангамжуудыг ашигласнаар цахилгааны параметруудийг дэд станц хуваарилах байгууламжуудаас эгшин бүрт бодитоор авч тооцоог гүйцэтгэснээр тооцоо үнэн зөв болж горим төлөвлөхөд алдаа, хүндрэл байхгүй болсон.

2018 оны зуны бага ачааллын хэмжилт


2018 оны зуны бага ачааллын хяналт хэмжилтийг 6 дугаар сарын 20-ны өдрийн 03:00, 12:00, 16:00, 23:00 цагуудад Дархан, Сүхбаатар, Зүүнхараа, Хөтөл, Жаргалант салбарын 35 кВ-ын 23 дэд станц, 6/0.4, 10/0.4 кВ-ын 595 дэд станцад хийж гүйцэтгэсэн.

Хэмжилтэнд нийт 42 бригадын 84 ажилтан зааварчилгаа авч, хуваарийн дагуу ажиллаж ЦДҮС ТӨХК болон ДДЦС ТӨХК-ийн инженерүүдтэй ачааллын хэмжилтийн дүнг тулган протокол үйлдэн баталгаажуулсан.

Компанийн хэмжээнд нийт 238 дэд станцын ухаалаг тоолуураас шууд мэдээлэл хэмжилтийн дүнг боловсруулан авч байгаа нь хүн хүч, машин механзмын зардлыг тодорхой хэмжээгээр хэмнэж байна.

Компанийн хэмжээнд 80%-86% ачаалагдаж байгаа 2 дэд станц, 90%-иас дээш ачаалагдаж байгаа дэд станц зуны бага ачааллын үед байхгүй байна.

д/д	Хэмжилтийн цаг	Нийт чадал мВт
1	03:00	39,11 мВт
2	12:00	48,45 мВт
3	16:00	48,87 мВт
4	23:00	65,13 мВт



2018-2019 оны өвлийн горимд шилжсэн тухай

Өвлийн горимын схемийг боловсруулан 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр батлуулж, 2018 оны 9 дүгээр сарын 17-ноос 2018 оны 9 дугаар сарын 30-ны хооронд өвлийн горимд бүрэн шилжиж дууслаа.

Өвлийн горимд шилжих үед

- ТП-15 Трансформатор гэмтэлтэй
- ТП-70 трансформатор байхгүй
- ТП-74 / жимс / 6кВ-ын кабель шугам гэмтэлтэй
- ТП-49 трансформатор гэмтэлтэй
- ТП-85, 81, 82, 77, 79, 84, 93, 88-д тоолуур байхгүй гэсэн зөрчлүүд

илэрсэнийг хэвийн болгосон.

3.3.ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТУРШИЛТ, ТОХИРУУЛГА, ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫН ГРАФИКИЙН БИЕЛЭЛТ

• 2018 онд 35кВ-ын 29 дэд станцад хэмжилт хийхэд 3510 км зам туулж 4,5 сая төгрөгийн зардал гаргасан байна. Энэ үеэр 35кВ-ын 105 цэнэг шавхагч туршилтанд орсоноос 3 цэнэг шавхагчийн гэмтлийг илрүүлж устгасан, аянгын улирлын бэлтгэл ажлын графикайн дагуу 110кВ-ын 11 дэд станцаас гарсан 6,10,35кВ-ын 45 гаргалгааны анкер тулгуурын газардуулгын эсэргүүцлийг хэмжсэн.

- 6,(10)кВ-ын гаргалгааны 39 анкер тулгуурт нийт 117ш цэнэг шавхагчид хэмжилт тохируулга хийсэн. Энэ ажлын хүрээнд РТ цэнэг шавхагч 33ш, РВО цэнэг шавхагч 15ш, Орос улсын ОПН цэнэг шавхагч 69ш тус тус хэмжилт тохируулгад хамрагдсан. 5 дэд станцад өндөр хүчдлийн туршилт хийж бүгд туршилт даасан байна.


- Мөн 6кВ-ын 16 фидерийн кабель шугам хэмжилт туршилт хийж, өвлийн бэлтгэл хангасан.

- Хэмжилт, туршилт үр дүнтэй хийгдсэн учир 2018 оны аянгын улирлын үеэр ямар нэгэн гэмтэл саатал гараагүй, хэт хүчдлийн хамгаалалтууд бүгд зөв ажилласан байна.

- 2018 онд хэрэглэгчийн хүсэлтээр 38 дэд станцад туршилт хийж, 50 кабель шугам хэмжсэн байна.

Д/д	Туршилт хэмжилт хийсэн тоноглолын жагсаалт	Нийт туршсан	Туршилтанд тэнцсэн	Туршилтанд тэнцээгүй
1	35кВ-ын цэнэг шавхагч	105	102	3
2	Дэд станц	38	38	0
3	Кабель шугам	50	50	0
4	Тоноглол	38	38	0
	Нийт дүн	231	228	3

2018 онд туршилтанд орсон шугам, тоноглолыг графикаар харуулъя



Засвар, барилга угсралтын ажлын технологийн картын мөрдөлт

"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ-с боловсруулсан технологийн картын дагуу 0.4,6(10),35кВ-ын бүх хүчдэлийн түвшний агаарын шугамын ажил, 35/6(10)кВ-ын дэд станц, 6(10)кВ-ын хуваарилах байгууламж, 6(10)/0.4кВ-ын дэд станцын тоноглолын угсралт, засвар, шинэчлэл, өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



Засвар, барилга угсралтын ажилд хэрэглэсэн материал сэлбэгийн үйлдвэрийн паспорт, гарал үүсэл, чанарын баталгаажуулалт

2018 онд шинээр барьсан 6/0.4кВ-ын 2*400кВА чадалтай дэд станцыг DIN EN 62271-2008 DIN EN 60694 стандартын дагуу герман улсын UESA компанийн тоноглолоор угсарсан. Мөн 0,4кВ-ын рубильникуудыг UESA, Хүчний трансформаторыг IEC 60076 стандартын дагуу ОХУ-н УПА, бүрээстэй дамжуулагч утсыг ГОСТ 52373-2005 стандартын дагуу СИП иркутск кабель ОАО зэрэг компаниудаас худалдан авч суурилуулсан.

Засвар барилга угсралтын ажлыг техникийн нөхцөл, зургийн даалгаврын дагуу хийсэн.

2018 онд 0.4кВ-ын 70км агаарын шугам, 35кВ-ын 20км агаарын шугам, Сургалтын полигон, 6/0,4кВ-ын 10 дэд станц, 3ш радио цамхаг, 35/10кВ-ын дэд станцын 35кВ-ын ОРУ шинэчлэх, 11864ш 1 фазын ухаалаг тоолуур суурилуулалт, 6кВ-ын 1,5км кабель шугам, 6(10)кВ-ын 15км агаарын шугам угсралтын ажлууд батлагдсан 21ш ажлын зураг, 20ш техникийн нөхцлийн дагуу хийгдэж засварын ажлын комисс хүлээж авсан.



4.ТЕХНИКИЙН БОДЛОГО

4.1.ӨВЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫН БИЕЛЭЛТ

2018-2019 оны өвлийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг Дэд захирал бөгөөд Ерөнхий инженерээр батлуулж, ашиглалтын үйл ажиллагааны 14, автомашин механизмын засварын 2, аж ахуйн ажилтай холбоотой 1, нийт 17 төрлийн ажлыг төлөвлөж ажилласан. Өвлийн бэлтгэл хангах ажлыг 100% хийж гүйцэтгэсэн бөгөөд төлөвлөгөөний гүйцэтгэлийг доорхи хүснэгтээр дэлгэрэнгүй үзүүлэв.

№	Д/Д	Хийгдэх ажлууд	Гүйцэтгэх хугацаа	Ажлын гүйцэтгэл	Гүйцэтгэл
1.Ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой ажил					
1	1	2018 оны төлөвлөгөөт их засварын 10 ажлаас графикт хугацаанд нь бүрэн чанартай хийж дуусгах	2018 оны 10 сарын 30-ны дотор	Их засварын 10 ажлаас 10 ажлыг хийж 100% гүйцэтгэсэн.	100%
2	2	Хүчдэлийн уналттай айл өрхийн судалгаа гаргаж чанартай цахилгаан эрчим хүчээр хангах ажил	2018 оны 10 сарын 01-ны дотор		
3	3	2018 оны төлөвлөгөөт ТЗБАХ-ын 15 засварын ажлыг графикт хугацаанд нь бүрэн чанартай хийж дуусгах	2018 оны 10 сарын 30-ны дотор	ТЗБАХ-ын 15 ажлаас 15 ажлыг 100% хийгдсэн.	100%
4	4	2018 оны төлөвлөгөөт хөрөнгө оруулалтын 13 ажлыг графикт хугацаанд нь бүрэн чанартай хийж дуусгах	2018 оны 8 сарын 30-ны дотор	Хөрөнгө оруулалтын 13 ажлаас 13 ажил нь 100% хийгдсэн. Ухаалаг тоолуур суурилуулах ажил үргэлжлэн хийгдэж байна.	100%
5	5	2018 оны төлөвлөгөөт 358 урсгал засварын ажлуудыг графикт хугацаанд нь бүрэн чанартай гүйцэтгэж дуусгах	2018 оны 11 сарын 15-ны дотор	Урсгал засварын 358 ажлаас 358 ажлыг хийж 100%-н гүйцэтгэлтэй байна.	100%
6	6	2018 оны ээлжит болон ээлжит бус эргүүл үзлэгийг компанийн бүх цахилгаан байгууламж, дэд станц, АШ, тоног төхөөрөмжинд графикайн дагуу хийж, үзлэгээр илэрсэн гэмтэл зөрчлүүдийг бүрэн засварлан хэвийн болгосон байх	2018 оны 11 сарын 15-ны дотор	2018 онд 8876 цэгт ээлжит эргүүл үзлэг хийхээр төлөвлөсөн. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 100% хийж гүйцэтгэсэн.	100%
7	7	Өвлийн горимын схемд шилжин ажиллах бэлтгэлийг хангах, бүх шугам тоноглолд ээлжит бус үзлэгийг явуулж, илэрсэн	2018 оны 11 сарын 20-ны дотор	Салбар тус бүр өөрийн эзэмшлийн шугам тоноглолдоо үзлэг хийж илэрсэн зөрчлийг устган өвлийн горимд шилжин	100%




		гэмтэл зөрчлийг устган шугам тоноглолыг их ачаалалын өмнө бэлэн байлгах		ороход бэлтгэж гүйцэтгэл 95%-тай байна.	
8	8	Өвлийн горимын схемийг боловсруулан шинэчлэн батлуулж өвлийн горимд шилжин орох	2018 оны 10 сарын 01-ны дотор	2018 оны 09-р сарын 14-ны өдөр өвлийн горимын схем батлуулсан. 09-р сарын 17-ны өдрөөс өвлийн горимд 100% шилжиж хэвийн ажиллаж байна.	100%
9	9	35/6(10) кВ-ын дэд станц, хуваарилах байгууламжийн дотор монтаж халаагуурт үзлэг шалгалт хийх	2018 оны 10 сарын 15-ны дотор	РП-2,3 ХХБ-ийн монтаж бүрэн сэргээсэн. Үзлэгээр илэрсэн РП-1 ХХБ, 35кВ-ын Чулуункарьер дэд станцын монтаж шинэчлэх ажлуудыг барилгын засварын ажилтай уялдуулан 100% хийсэн	100%
10	10	6 (10)кВ-ын кабель шугамд өндөр хүчдлийн туршилт хийх	2018 оны 10 сарын 15-ны дотор	9 дүгээр сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн.	100%
11	11	Хүчний трансформаторууд, тосон таслуур, бусад тосон дүүргэлттэй тоноглолуудад шаардлагатай тосны нөөцийг бэлтгэх	2018 оны 11 сарын 01-ны дотор	Аваарийн нөөц материалын жагсаалтыг 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдөр шинэчлэн батлуулсан.	100%
12	12	Аваарийн нөөц материалын жагсаалтыг шинэчлэн батлуулж бүрдүүлэлт хийх	2018 оны 10 сарын 15-ны дотор	Аваарийн нөөц материалын бүрдүүлэлт хийгдэж байна. 6(10)/0.4кВ-ын хүчний трансформаторын бүрдүүлэлт хангалтгүй байсан. Үүнийг трансформатор засварын хэсгээс бүрдүүллээ.	
13	13	Сумдын уурын зуух болон дулааны станцтай хэрэглэгчдэд албан мэдэгдэл өгөх, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг чанаржуулах	2018 оны 10 сарын 01-ны дотор	Салбар нэгжийн дарга нар өөрийн үйлчлэх хүрээндээ үйл ажиллагаа явуулж байгаа сумдын уурын зуух дулааны станцад нөөц тэжээлийн бэлэн байдлыг шалгах, байхгүй бол бэлтгэх талаар албан бичиг хүргүүлэн ажилласан.	100%
14	14	Цахилгаан эрчим хүчээр халаалтын системээ шийдвэрлэсэн айл өрх, ААНБайгууллагад албан шаардлага өгөх	2018 оны 10 сарын 01-ны дотор	Цахилгаан эрчим хүчээр халаалтаа шийдвэрлэсэн айл өрх аж ахуй нэгжүүдэд мөн мэдэгдэл хүргүүлж ажиллаа.	100%



Дүн				100%	
2.Авто машин механизмын үйл ажиллагаатай холбоотой ажил					
15	1	Компанийн төвийн болон салбар нэгжүүдийн машин механизмуудын дулаалга болон өвлийн дугуйнд үзлэг шалгалт хийх	2018 оны 10 сарын 01-ны дотор	2018 оны 09-р сарын 10-14-ны өдрүүдэд ТҮАААлбаны дарга Н.Машбат салбар нэгжүүдийн машин механизм болон конторын дулаан холбогдоход бэлэн эсэхэд үзлэг хийсэн. Сүхбаатар салбарын дулааны узелийн 2ш тунгаагуур сольсон. Жаргалант, Сүхбаатар салбарын крануудад шинээр дугуй худалдан авч суурилуулсан.	100%
16	2	Төвийн болон салбар хэсгүүдийн машин механизмуудын гражийн халаалтын системийн хэвийн ажиллагааг хангаж халаалт авхад бэлтгэх	2019 оны 10 сарын 01-ны дотор		100%
Дүн				100%	
3.Аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой ажил					
17	1	Компанийн төв оффиссын болон салбар хэсгүүдийн конторын халаалтын системд үзлэг хийж халаалт авхад бэлтгэх	2018 оны 10 сарын 01-ны дотор	2018 оны 09-р сарын 10-14-ны өдрүүдэд ТҮАААлбаны дарга Н.Машбат салбар нэгжүүдийн машин механизм болон конторын дулаан холбогдоход бэлэн эсэхэд үзлэг хийсэн. Дулааны гэрээнүүдийг шинэчлэн хийсэн.	100%
Дүн				100%	
Нийт дүн				100%	

4.2. ИХ ЗАСВАР, ТЗБАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2018 онд Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын 38 ажлыг 4,9 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс өнөөдрийн байдлаар 38 ажлыг хийж ажлын гүйцэтгэл Их засварын ажил 100%, ТЗБАХ-ын ажил 100%, Хөрөнгө оруулалтын ажил 100%, нийт өвөлжилтийн бэлтгэл ажлын 100%-н гүйцэтгэлтэй байна.




Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын ажлаар 35кВ-ын 20км, 0.4кВ-ын 61.9км, 6,10кВ-ын 12км агаарын шугам шинэчлэх, 6/0.4кВ-ын 6 дэд станц шинээр барих, 6кВ-ын 0.6км кабель шугам, 35/10.6кВ-ын 3 трансформаторт засвар хийх, 8 хуваарилах байгууламжид барилгын засвар, склада мэдээлэл дамжуулах 3 цамхаг шинэчлэх, 794ш хайрцаг тавьж 9211ш ухаалаг тоолуур суурилуулах ажлуудыг хийгээд байна.



- 35кВ-ын агаарын шугамын шинэчлэлтийн ажлаар

Нэг талын тэжээлтэй Хушаат сумыг ЦЭХ-ээр хангадаг 35кВ-ын Энхтал агаарын шугамын тасралтыг бууруулж хэрэглэгчдийг тасралтгүй цахилгаан

эрчим хүчээр зорилгоор 132 ш тулгуурыг төмөр бетон тулгуураар сольж, 20км агаарын шугамыг шинэчилсэн.




- **35/10,6кВ-ын трансформатор, дэд станцын засварын ажлаар**

35/10кВ-ын Зүүнбүрэн дэд станц, Жаргалант дэд станцын насжилт өндөртэй хүчний трансформаторыг гэмтлээс урьдчилан сэргийлж бүрэн засвар хийж гүйцэтгэсэн.

35/10,6кВ-ын Угтаал, Хэрх, Чулуун карьер, 6кВ-ын РП-1,2,3,6, Хөтөл РП-1 нийт 8 дэд станцын дээвэр болон дотор, гадна өнгө үзэмж сэргээх, барилгын дулаан алдалтыг багасгаж засвар хийсэн.



35/10кВ-ын Түнхэл дэд станцын шинэчлэлийн ажлаас буусан тоноглолуудыг ашиглан сургалтын иж бүрэн полигоныг барьж 2017 оны 5 дугаар сард ашиглалтанд оруулсан. Уг дэд станцыг барьснаар 35/10кВ-ын анхдагч болон 2 догч хэлхээний сургалт, агаарын шугамын угсралт, хэмжүүрийн сургалтыг шинээр ажилд орсон болон дадлагын оюутнуудад сургалт өгөх мөн ААД, ТАД, сэлгэн залгалтын шалгалт авч байна.



Дархан сумын хуучин хорооллын 6/0.4кВ-ын 4 дэд станцын оролт болон секц холбогч АВМ-уудыг шинэчлэн ІЕК-н автоматаар сольж найдвартай ажиллагааг дээшлүүлсэн.

- **0.4кВ-ын агаарын шугамын шинэчлэлтийн ажлаар**

Дархан, Сүхбаатар, Заамар суманд нийт 23 дэд станцын 61.96км 0.4кВ-ын агаарын шугамыг төмөр бетон тулгуур бүрээстэй дамжуулагчаар шинэчлэх ажил хийсэн.



Дархан сумын 2,5,6,8,15-р баг Орхон суманд шинээр нэмэгдсэн 222 хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж 8км 0.4кВ-ын агаарын шугам, шинээр барьсан.




Дархан сумын 6/0.4кВ-ын ТП-553-с ТП-2 дэд станц руу 350м 6кВ-ын кабель шугам татаж, хуучин хороолол хэсгийг кольцо схемтэй болгосон.

- **6(10)/0.4кВ-ын дэд станц шинээр барих ажлаар**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3-р багийн аж ахуйн нэгжүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах, цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах зорилгоор 6/04кВ-ын дэд станц 6/0,4кВ-ын 2*400кВА чадалтай дэд станцыг Герман улсын Siemens фирмийн ачаалал таслагч, MRI, MRA микропроцессор реле хамгаалалт суурилуулж, Итали улсын хуурай трансформатор, 0,4кВ-ын гаргалгаанд блок рубильникоор бүрэн тоноглон шинээр барьж, хяналт удирдлагын системд холбосон.



Дархан Уул аймгийн Дархан сум, Хонгор суманд шинээр нэмэгдсэн хэрэглэгчдийг ЦЭХ-р хангах 6/0,4кВ-ын 5 дэд станц шинээр 0,4кВ-ын 2км агаарын шугамын хамт барьсан.





- Ухаалаг тоолуур суурилуулах ажлаар

2018 онд 794ш тоолуур төвлөрүүлэх хайрцаг угсарч 9122ш ухаалаг тоолуур суурилуулж мэдээллийн автоматжуулсан системд холбосон.



2018 онд 35/6 кВ-ын Хонгор дэд станц, 35/10кВ-ын Цагааннуур дэд станц, 35/10кВ-ын Шаамар дэд станц 3 дэд станцыг диспетчерийн хяналтын системд нэвтрүүллээ. Ингэснээр ДСЦТС ХК-ийн өөрийн эзэмшлийн 35,6,10кВ-ын 27 дэд станц, хуваарилах байгууламжинд 100% диспетчерийн хяналтын системд бүрэн холбогдон ажиллаж байна.

Сүхбаатар, Зүүнхараа, Жаргалант салбарт диспетчерийн хяналтын системийг суурилуулж салбарын диспетчер өөрийн үйлчлэх хүрээний дэд станц, хуваарилах байгууламжийг бүрэн хянаж байна.



- Диспетчерийн хяналтын системийн талаар

Тус компанийн инженер, техникийн ажилчид судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд мэдээлэл дамжуулах сүлжээ 3G технолги нь анхны хөрөнгө оруулалт

шаардахгүй ч цаашид гарах зардал өндөр байсан учир Радио технологийг сонгож мэдээллийг өндөр хурдны нарийвчлалтай авах зорилт тавин ажилласан. Үүнд: 2018 онд стандартын дагуу Дархан сумын нутагт 3 өндөрлөг цэгт 12 метрийн өндөртэй радио цамхаг босгож хоорондоо кольцо сүлжээнд оруулан РП-үүдийн мэдээлэл болон хяналтын камерын мэдээллийг өндөр хурдны Радио долгион ашиглан диспетчер дээр хянаж байна.



ТАВ. ХАМТ ОЛНЫ ОЮУНЫ ЧАДАВХИЙН ҮНЭЛЭМЖ

5.1.ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ /инноваци/

5.1.1 “ЦЭХ-ний хяналт удирдлага арилжааны автоматжуулалтын систем”-ийн уялдаа, холбоог сайжруулах, гар ажиллагааг хөнгөвчлөх зорилготойгоор 2018 онд “ХАЦЭХ-ний энерги, баланс тооцооны систем”-ийг шинээр нэвтрүүлсэн

2012 онд Хятад улс руу явж ухаалаг тоолуур, ухаалаг системийн талаар судалгааны ажил хийсэн. Ухаалаг тоолуурыг 2012 оны өвөл 1 дүгээр сард Дархан хотын Хараа голын эрэг дээр гэр хорооллын АТП-111 /хамгийн урт трасстай 1200 метр/ дэд станцын 0,4кВ-ын тоолуур төвлөрүүлсэн хайрцаганд 5 ширхэг суурилуулж, анх удаа туршилт хийсэн. Энэ туршилтаар тоолуурын мэдээллийг 3 цагийн давтамжтайгаар цахилгааны шугамаар /PLC Power Line communication/



мэдээллээ дамжуулан 3G сүлжээгээр компанийн төв серверт авсан.

Туршилтын үр дүнд бүх үзүүлэлтүүд эерэг гарч ухаалаг тоолуур нь өвлийн улиралд гадаа -42⁰C градуст дэлгэц царцаагүй, гацалтгүй, мэдээллээ хэвийн дамжуулж байсан тул нэг фазын CL710K1 маягийн PLC модультай ухаалаг тоолуурыг АС болон бүрээстэй дамжуулагч утастай сүлжээнд ашиглаж болно гэсэн дүгнэлтэд хүрч Ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.

Орон сууцны айл өрхүүдэд ухаалаг тоолуурын RS485 холболтоор сүлжээ байгуулан суурилуулах нь оновчтой гэж үзэн суурилуулалтын хийсэн.

2018 онд дээрх судалгаанд тулгуурлан "Цахилгаан эрчим хүчний хяналт удирдлага арилжааны автоматжуулалтын систем" буюу "Ухаалаг тоолуурын систем"-ийг нэвтрүүлж, байнга сайжруулж байна.

ЦЭХ-ний хяналт удирдлага арилжааны автоматжуулалтын систем"-ийн уялдаа, холбоог сайжруулах, гар ажиллагааг хөнгөвчлөх зорилготойгоор 2018 онд "ХАЦЭХ-ний энерги, баланс тооцооны систем"-ийг шинээр нэвтрүүлж, компанийн хэмжээнд 12 систем ажиллаж байна.

Үүнд:

- 1) Борлуулалт арилжааны систем
- 2) Хэрэглэгчийн онлайн систем
- 3) ХАЦЭХ-НИЙ ЭНЕРГИ, БАЛАНС ТООЦООНЫ СИСТЕМ**
- 4) Тоолуурын хяналт удирдлагын систем /AMI system/
- 5) Нэгтгэлийн програм хангамж
- 6) Хүний нөөцийн програм хангамж
- 7) Техник ашиглалт засвар үйлчилгээний програм
- 8) Диспетчерийн хяналтын систем
- 9) Эрчим хүчний системийн дүн шинжилгээний програм хангамж
- 10) Санхүү эдийн засгийн цогц систем
- 11) Тээврийн хэрэгслийн хяналтын систем
- 12) Хяналтын камерын систем

5.1.2 Ухаалаг тоолуурын хяналт удирдлагын системийг шинэчилж олон улсын стандартыг ханган ажиллах, системийг нэвтрүүлэн ажиллаж байна

2018 онд AMI системийн шинэчлэх гэрээ хийж, олон улсын стандартын шаардлага хангасан DLMS, COSEM, IEC62056, QGDW-376 протоколуудыг дэмждэг, IEC61968 протокол хангасан 3-дагч програмуудтай шууд холбогдох, урьдчилсан төлбөрт системд шилжин ажиллах, ус, дулаан, хий гэх мэт бусад түгээлтийн

системд ажиллах, системээс тоолуурын тарифын цаг тохируулах, концентраторын тохиргоо хийх, унтрааж асаах зэрэг давуу талуудтай системийн нэвтрүүлэлт хийж байна.




Системийн ерөнхий бүтэц



5.1.3. Хэрэглэгчийг үнэн бодит мэдээллээр хангах, алтан цаг завьг нь хэмнэх зорилгоор “Цахилгаан” гар утасны аппликейшн нэвтрүүлээ.

Дэлхийн аль ч улс орноос “ЦАХИЛГААН” гар утасны аппликейшнийг нэвтрүүлж Андроид болон IOS үйлдлийн систем бүхий бүх төрлийн гар утас, таблетад татан авч, хэрэглэгчид хэрэглээгээ хянах, төлбөр төлөх, НӨАТУС-аар баримт авах, гэрээгээ сунгах, өргөдөл гомдол илгээх, тоолуурын мэдээлэл харах зэрэг бүхий л мэдээллийг харах, хянах боломжтой болсон.



5.1.4. Борлуулалтын арилжааны системийг банктай онлайн болгосон


Банктай онлайн болгох ажлын хүрээнд МОСТ МОНИ ХК, Голомт банкны баазтай тест хийж Дархан-ХҮТ, Сүхбаатар салбар, Зүүнхараа салбар, Хөтөл салбар нэвтрүүлэн ажиллалаа. Капитрон, Худалдаа хөгжлийн банк, Голомт банкаар орж ирж байгаа орлого шууд орлогод авагддаг болсон



Тайлбар	Хугацаа	Хэмжээ	Төрөл	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр
...

5.1.5 Веб сайтыг компанийн програм хангамжийн инженерүүд Монгол, Англи дээр хийж шинэчилсэн



Компанийн веб сайт шинэчлэлтийн ажил хийгдэж 95%-тай явагдаж байна.



5.1.6 Диспетчерийн хяналтын системийг өргөжүүлэн ажиллаж байна

2018 онд 35/6 кВ-ын Хонгор дэд станц, 35/10кВ-ын Цагааннуур дэд станц, 35/10кВ-ын Шаамар дэд станц 3 дэд станцыг диспетчерийн хяналтын системд нэвтрүүлээ. Ингэснээр ДСЦТС ХК-ийн өөрийн эзэмшлийн 35,6,10кВ-ын 26 дэд станц, хуваарилах байгууламжинд 100% диспетчерийн хяналтын системд бүрэн холбогдон ажиллаж байна.

Сүхбаатар, Зүүнхараа, Жаргалант салбарт диспетчерийн хяналтын системийг суурилуулж салбарын диспетчер өөрийн үйлчлэх хүрээний дэд станц, хуваарилах байгууламжийг хянах бүрэн боломжтой болсон.




Диспетчерийн хяналтын дэлгэц дээр SCADA систем суурилагдсан нийт дэд станцын ачааллыг салбар болон нийт дүнгээр хардаг болсон



5.1.7 Хонгор дэд станцад 3 ш, Цагааннуур дэд станцад 3 ш Дархан түгээх төвийн гадна 1 ш, ХҮТ-2 д 4ш, цамхаг бүр дээр 2 ширхэг нийт 8 ш хяналтын камер, нийт 19 ширхэг камер суурилуулж, холболтыг хийж гүйцэтгэсэн

2018 оны байдлаар компанийн хэмжээнд хуваарилах байгууламж, дэд станц, оффист нийтдээ 151 ширхэг камерыг суурилуулан хянаж байна.



2013-2018 онд нийт 44367 хэрэглэгчид ухаалаг тоолуур суурилуулсан. Үүнээс гэр хорооллын 27254 айл өрх, орон сууцны 16143 айл өрхөд суурилуулаад байна. Ухаалаг тоолуур суурилуулж хяналт удирдлагын автоматжуулсан системд холбосноор зүй бус алдагдалгүй болж, 0,4кВ-ын сүлжээний алдагдал 21,3 хувиас 5 хувьд хүрч борлуулалтын орлого нэмэгдэж байна. Ухаалаг тоолуур тавигдсан дэд станцуудын тоолуур төвлөрүүлээгүй 2012 оноос өмнөх үе, агаарын шугамыг СИП утастай болгон тоолуурыг нэгтгэж төвлөрүүлсэн үе, ухаалаг тоолуур тавьж хяналт удирдлагын автоматжуулсан системд холбосны дараах үзүүлэлтүүдийг графикаар харуулбал:



Тоолуур нэвтрүүлснээр гарсан үр дүн:

1. Тоолуур өндөр нарийвчлалтай тул ЦЭХ-ний алдагдал буурч, зүй бус хэрэглээ эрс буурч 0, 4 кВ-ын сүлжээний алдагдал 5 хувьд хүрсэн.
2. Таслах залгах үйлдэл автоматаар хийгдэн үйлчилгээг хурдан шуурхай үзүүлж, ЦЭХ-ний өр авлага жилд дунджаар 30-40% буурч, авлага буурч байна.
3. ЦЭХ-ний түгээлтийн алдагдал буурснаар борлуулалтын орлого нэмэгдсэн.
4. Хэрэглэгчийн хэрэглэсэн бодит чадлын утгыг хугацааны эгшин бүрт шаардлагатай хугацаагаар авч үнэн зөв гаргаж байна.
5. Чадлын утгыг бодитой гаргаснаар хэрэглэгч хангагчын хооронд тооцооны маргаангүй болсон
6. Хоногийн ачааллын болон хэрэглээний графикийг 24 цагийн турш өндөр нарийвчлалтай гаргаж, хангагч хэрэглэгч хэрэглээний графиктаа хяналт тавих боломжтой болсон.
7. Дэд станц, хуваарилах байгууламжаас биечлэн авдаг байсан сарын тоолуурын заалтыг автоматаар авч, хүн хүч, цаг хугацаа хэмнэх болсон.
8. 0,4кВ-ын шугам сүлжээ бүрэн шинэчлэгдэж хэрэглэгчийн цахилгаан хангамж сайжирч найдвартай болсон.
9. Өдөр, шөнийн 2 тарифаар тооцдог тул хэрэглээгээ хянаж, эдийн засгийн хэмнэлттэй байх боломжтой.

РАДИО ДОЛГИОНЫГ АШИГЛАН ДИСПЕТЧЕРИЙН ХЯНАЛТЫН СИСТЕМ, КАМЕРЫН СИСТЕМИЙН МЭДЭЭЛЛИЙГ АВЧ БАЙНА.

Компанийн инженер, техникийн ажилчид судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд мэдээлэл дамжуулах сүлжээ 3G технологи нь анхны хөрөнгө оруулалт шаардахгүй ч цаашид гарах зардал өндөр байсан учир Радио технологийг сонгож мэдээллийг өндөр хурдны нарийвчлалтай авах зорилт тавин ажилласан.

Үүнд: 2018 онд стандартын дагуу Дархан сумын нутагт 3 өндөрлөг цэгт 12 метрийн өндөртэй радио цамхаг босгож хоорондоо кольцо сүлжээнд оруулан РП-үүдийн мэдээлэл болон хяналтын камерын мэдээллийг өндөр хурдны Радио долгион ашиглан диспетчер дээр хянаж байна.



6.ҮЗЛЭГИЙН ДҮН

6.1.ХӨДӨЛМӨРИЙН САХИЛГА, АЖЛЫН ЦАГ АШИГЛАЛТ

2018 онд ажилтнуудын хөдөлмөрийн сахилга, дэг журмыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн дотоод журмын дагуу тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон заавар, журам, хууль эрхийн актууд, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, ТАД, ААД, ГАУС дүрэм, ажлын цаг ашиглалт, үүрэг даалгаврын биелэлт, технологийн заавар, журмын заалтыг зөрчсөн сануулах 3, үндсэн цалинг бууруулах арга бууруулах арга хэмжээ 5, нийт 8 ажилтанд сахилгын арга хэмжээ авагдсан байна.

2018 онд Компанийн салбар, нэгжүүдийн цаг ашиглалтыг авч үзвэл давхардсан тоогоор томилолтой 4424 өдөр ,өвчтэй 1573 өдөр , чөлөөтэй 463 өдөр, жирэмсний амралттай 874 өдөр тасалсан 143 өдөр, ээлжийн амралттай 212 өдөр хүүхэд асрах чөлөөтэй 168 өдөр байна.



“ДСЦТС ХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам”, “Ажлын цаг ашиглалтыг тооцох, хяналт тавих журам” /нүүрээр болон хурууны хээгээр бүртгэх төхөөрөмж тавьсан/-ын дагуу цагийн бүртгэлийн мэдээллийг өдөр тутам 16 нэгжээс өдөр бүр авч нэгтгэн, өглөөний шуурхайд өдөр бүр танилцуулан, цагийн бүртгэл, цаг ашиглалтад хяналт тавьж ажиллалаа.

6.2.ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ГАУС-ЫН АЖЛЫН БИЕЛЭЛТ

Компанийн ажилтан ажилчдыг ажлын тусгай хувцас гутал, хамгаалах хэрэгслээр хангах зардалд 287,3 сая төгрөг, галын аюулаас урьдчилан сэргийлэх зардалд 2.1 сая төгрөг буюу нийт 289,4 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэл ХАБЭА-н зардал 305,7 сая төгрөг, галын аюулаас урьдчилан сэргийлэх 40,1 сая төгрөгийг тус тус зарцуулж, нийт 345,8 сая төгрөгийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ГАУС-ын зардалд зарцууллаа.

Мөн Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал ISO45001:2018 менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд 60,7 сая төгрөгийн Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, сургалтанд 10,8 сая төгрөг нийт 71,5 сая төгрөгийг зарцуулсан.

Ийнхүү шат дараатай дараах арга хэмжээнүүдийг авч ажилласны үр дүнд 2018 онд *НЭН ТҮРҮҮНД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ” зарчимд тулгуурлан “ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ”-гүй ажилласан. Үүнд:



ДСЦТС ХК нь аюул эрсдлээс урьдчилан сэргийлэх залруулах, аюул, эрсдэлгүй ажлын байр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог сайжруулах, осол зөрчилгүй ажиллах зорилгоор **ISO-45001** ХЭМАБ-ын олон улсын удирдлагын системийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Стандартын хүрээнд:

1. ХЭМАБ-ын бодлого, зорилго, хөтөлбөр
2. 214 үйл явцын эрсдлийн үнэлгээ
3. 120 зааврыг шинэчилж боловсуулж бүртгэсэн
4. Гамшгаас хамгаалах,онцгой байдалд хариу арга хэмжээ үзүүлэх төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан
5. Эрсдлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.аюулгүй ажиллагааны зааврууд боловсруулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд **330,3 сая** төгрөгийг зарцуулсан бөгөөд хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл, галын булангийн багаж, хэрэгсэлд хяналт тавих хяналтын тогтолцоог сайжруулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, ААД, ТАД-ийн шаардлагуудыг хангаж ажиллах хүрээнд:

2018 онд компанийн хэмжээнд хийгдэх **6313** захиалгат ажлыг хянаж, нарыдаар **2680**, шийдвэрээр **3633** гүйцэтгэх ажлын захиалга, зааварчилгаа, бригадыг хянаж ажилласан байна.

ХАБЭА-н анхан шатны үзлэгийг **5012**, II шатны үзлэгийг **533** нийт **5545** үзлэгийг хийж Салбар, төв, алба нь журмын дагуу зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан.

ХАБЭА-н хяналтын үзлэгүүдээр шугам, тоноглол, дэд станц, ХБ, ТП-нүүдийн диспетчерийн нэр хаяг, урьдчилан сэргийлэх плакат тэмдгийн байдалд үзлэгийг хийж байгаа ба тухай бүр үүрэг даалгавар өгч зөрчлийг арилгуулж байна. Үзлэгийн мөрөөр зохиосон ажлуудыг хүснэгтээр харуулбал:

д/д	Хийгдсэн ажил	2018 он
1	Шинэчилсэн аюулгүй ажиллагааны плакат	4748
3	АШ тулгуур дугаарласан сэргээсэн	2965
4	Дэд станц ХБ нэр хаяг сэргээсэн	912
5	Шинээр цоож цүү хийсэн	1468
6	Шинээр болон давтан газардуулга хийсэн тоо	478



Аюулгүй ажиллагааны плакат тэмдэг, диспетчерийн нэр хаяг сэргээсэн байдлыг салбар хэсэг нэгжээр харуулбал:

Д/Д	Салбар нэгжийн нэр	Шинэчилсэн аюулгүй ажиллагааны плакатны тоо	Диспетчерийн нэр хаяг сэргээсэн дэд станцын тоо
1	Сүхбаатар салбар	449	31
2	Зүүнхараа салбар	1036	669
3	Жаргалант салбар	79	11
4	Хөтөл салбар	220	8
5	ЗТТА	642	3
6	ШҮМА	132	12
7	ДХҮТ ерөнхий шит	1335	
8	ДТТ	1444	68
	НИЙТ ДҮН	5337	802

Компанийн хэмжээнд салбар алба төв ажилтнуудаа давхардсан тоогоор **52825** удаа анхан шатны, өдөр тутмын давтан зааварчилгаа, сарын давтан зааварчилгаа, ээлжит бус зааварчилгаа, тухайлсан зааварчилгаануудад хамруулсан.

2018 оны ээлжит сургалтыг зохион байгуулж 319 ажилтнаас ээлжит шалгалтыг авч 317 ажилтан тэнцэж, 2 ажилтан тэнцээгүй, шинээр 11 ажилтан орж шалгалтанд орсон байна.

ГАУС сургалтыг Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн ОБГ-тай хамтарч 3 удаа явуулж нийт давхардсан тоогоор 1148 ажилтан хамрагдсан байна. Шинээр баригдаж байгаа болон шинэчлэлт хийж байгаа дэд станцууд галын дохиоллын систем дулаан мэдрэгчтэй автоматаар ажилладаг гал унтраагуурыг суурилуулж байна.

Компанийн "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-д тодотгол хийж Дархан-Уул аймгийн Онцгой Байдлын Газрын холбогдох улсын хяналтын байцаагчаар хянуулж, Онцгой Байдлын Газрын дарга зөвшөөрч, компанийн Гүйцэтгэх захирлаар батлуулж мөрдөж байна.

Галын хор шалгах зааварт нэмэлт оруулж, стандартын загварт оруулан баталгаажуулж, галын анхан шатны багаж хэрэгсэл хариуцсан ажилтнуудыг

томилсон Гүйцэтгэх захирлын 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 385 тоот тушаал гаргасан.

Дархан –Уул аймгийн Онцгой Байдлын Газраас Ажлын байрны галын аюулгүй байдлын 01806817 дугаартай дүгнэлт, Зүүнхараа салбар Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газраас авсан.

Сүхбаатар, Зүүнхараа салбарын барилгыг хүлээн авахад галын дохиоллын систем монтажлуулан хүлээн авсан.

6кВ-ын РП-1,2,3,4,5,6,8,9,10,20,12, 13 дэд станцуудад ОСП-1 маркын гал унтраагуур нийт 86 ширхэг, 35/6 кВ-ын Ханжаргалан, Түнхэл, Заамар дэд станц, 35кВ-ын РП-11 ХХБ, 6/0,4кВ ТП-99 дэд станцуудад ХZFMB6ABC маркын гал унтраагуур 8 ширхэг, нийт 94 ширхэг галын хорыг суурилуулж галын аюулаас урьдчилан сэргийлж ажилласан. Мөн шинээр тавьсан ухаалаг тоолуурыг ГАУС-н дүрэмд нийцүүлэн сүүлийн үед нэвтэрч буй ухаалаг галын хорыг нэвтрүүлж байна.

2018-03-26-ны өдөр Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газраас Газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед хэрхэн ажиллах, өөрийгөө болон бусдын амь насыг эрсдэлд орохоос хэрхэн сэргийлэх чиглэлээр 2 цагийн сургалт явуулан дадлага сургууль хийгдсэн. Дадлага сургалтанд захиргаа техникийн 78 ажилтан хамрагдсан.



2018-03-28-ны өдөр Дархан Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн 51 ажилтанд газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед хэрхэн ажиллах, өөрийгөө болон бусдын амь насыг эрсдэлд орохоос хэрхэн сэргийлэх чиглэлээр дадлага сургалт хийсэн.



2018-03-29-ний өдөр зарлан мэдээлэх дохиогоор ажиллалаа. Компанийн захиргаа техникийн ажилтнуудад Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд, Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх таниулах Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг ОБГ-ын ахлах ахлагч М.Баянмөнхтай хамтран зохион байгуулан ажиллалаа.



2018-10-04-ний өдөр Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газартай хамтран Мэргэжлийн ангийн шинэчлэгдсэн дүрэм журам, төлөвлөгөөний дагуу Гал унтраах

дадлага сургуулилтийг 100 ажилтанд 6 цаг, “Хэн ч хаана ч хэзээ ч бэлэн байх” ур чадвар, хандлага олгох буухиа тэмцээ зохион байгуулсан.



2018-10-08-наас 15-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн Түлш эрчим хүчний албаны Гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургуулилт 7 хоног явагдаж, бэлэн байдал зарлаж, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний 55 ажилтан, штабын бүрэлдэхүүн 8 ажилтан ажилласан.

2018-10-12-ны өдөр Дархан-Уул аймгийн Дархан сумын 15-р багийн Мангиртын 9-р хэсгийн “Үерийн даланг сэргээх засварлах” ажлаар Мэргэжлийн цахилгаан техникийн аврах, эмнэлгийн анхны нөхөрлөлийн бүлэг, нийт 63 ажилтан, 9 машин механизм, 2.0 төгрөгийн зардлаар 225м³ эзэлхүүн шороо ухаж үерийн даланг хийж гүйцэтгэсэн.



6.3. АЖЛЫН БАЙРНЫ ЭМХ ЦЭГЦ

2018 онд төлөвлөгөөт 41 их засвар, 257 урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Засварын ажлын хүрээнд 35/10 Квын дэд тсанц, 6кВ-ын хуваарилах байгууламжийн барилгад 40 гаруй жил засвар үйлчилгээ хийгээгүй байсан учир их засвар хийж ажлын байрны эмх цэгцийг сайжруулсан. Цахилгаан түгээх сүлжээний ажилтнууд нь агаарын шугамын тулгуурт гарч ажил үйлчилгээ явуулдаг тул тэдгээрийн ажиллах нөхцөл маш хүнд байдаг. Энэ асуудлыг шийдэх зорилгоор 70км гэр хорооллын агаарын шугамыг төмөр бетон тулгуур, бүрээстэй дамжуулагч утсаар

шинэчилсэн. Энэ нь иргэдийн ая тухтай, галын аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлээд зогсохгүй ажилтнуудыг аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж ажлын байрны эрсдлийг бууруулсан томоохон ажил болсон.

35кВ-ын дэд станцуудыг камерийн хяналтын системд холбосноор ажилтнуудыг аюулгүй ажиллах, ажлын байрыг гадны халдлагаас урьдчилан сэргийлэх боломжийг бүрүүлсэн.

Ажилтнууд засварын ажлын үеэр ажлын цагыг хэтрүүлэн илүү цаг ажилладаг байсныг зогсоох зорилгоор захиалга авархдаа ажлын бус цагаар хийгдэх ажлуудын зхиалгыг авахгүй байх шийдвэрг гаргасан.

Тус компани нь 2018 оны 03 дугаар сараас эхлэн ISO9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO45001:2018 ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны стандартуудыг нэвтрүүлэх шатны ажлын хүрээнд:

- 1) Баримт бичгийн хяналтын журам
- 2) Албан хэрэг хөтлөлтийн журам
- 3) Архивын журам
- 4) Ажлын байрны соёл - 5S-ийн журмыг шинээр мөрдөж ажилласан.

5) Стандартын ажлын хүрээнд Бүтээмж чанарын өрөөнд барилгын засварт 2.0 сая төгрөг, Техник хэрэгслэл, тавилгын зардалд 6.2 сая төгрөг, нийт 8.2 сая төгрөгийн зардал зарцуулж ашиглалтад оруулсан.

Чанар бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор 5s бүтээмж нэмэгдүүлэх сургалтыг Төслийн менежер Т.Батжаргалтай хамтран явуулж, “Кайзен саналын журам”, Ажлын байрны соёл 5S-ийн журам”-уудыг батлуулсан.

Компанийн хэмжээнд Архив, албан хэрэг хөтлөлт, ажлын байрны эмх цэгцийг сайжруулах уралдаан зарласан.



Ажлын байрны соёл – 5S-ийн хүрээнд бичиг хэргийн хэрэгсэл, архив, бичиг баримтуудыг стандартын дагуу цэгцэлсэн.



Компанийн хэмжээнд хүний нөөцийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр 11 удаа сургалт явуулж, 345 ажилтныг хамрууллаа.

- ✚ Удирдах ажилтнуудын хандлага
- ✚ Хүний нөөцийн менежментийн ойлголт, чиг хандлага
- ✚ Манлайлал
- ✚ Бичиг баримт боловсруулах
- ✚ Эерэг хандлага
- ✚ Багшийн хандлага



2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Архив, албан хэрэг хөтлөлтийн баримт бичиг, ажлын байрны эмх цэгц, цаг ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд сарын аяны удирдамж гарган Гүйцэтгэх захирлаар батлуулан компанийн нэгж хэсгүүдийн дунд уралдаан зарлаж, удирдамжийн дагуу доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Компанийн хэмжээнд бүтээмж дээшлүүлэх, компанийн хөгжилд ажилтнуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх, ажлын байр бүрийн эмх цэгцийг хангуулах,



манлайллыг хөгжүүлэх, баг хамт олны бүтээн байгуулалтын ажлын шинэ санал санаачлагыг дэмжиж, ажилтнуудын ХАНДЛАГЫГ өөрчилж, байгууллагын соёлыг сайжруулах зорилгоор зохион байгуулж, уралдааныг дараах болзлын дагуу нийт 100 оноогоор шалгарууллаа. Үүнд:

1. Өрөө тасалгааны цэцэгжүүлэлт, өнгө үзэмж, тоог харгалзана /10 оноо/
2. ХАБЭА-н буланг тохижуулж, мэдээлийн самбарыг шинэчилсэн байдал /10 оноо/
3. Хөдөлмөр хөнгөвчлөх шинэ бүтээл, оновчтой санал дэвшүүлсэн байдал /20 оноо/
4. Ажлын байрны эмх цэгц, 5 С хэрэгжүүлсэн байдал /10 оноо /
5. Контор, өрөө тасалгаа /дэд станц, хуваарилах байгууламж/-ны доторх гадна, тохижилтыг сайжруулж, эмх цэгцтэй, өнгө үзэмжтэй болгох /20 оноо/
6. Гэрэлтүүлэг түүний бүрэн бүтэн байдал /5 оноо /
7. Өөрсдийн хүчээр дотоод нөөц бололцоогоо ашиглан ашиглагдахгүй байгаа зай талбай, эд материалаар өрөө тасалгааг тохижуулэх, ашигласан байдал /20 оноо/
8. Иргэдэд ойлгомжтой, өнгө үзэмжтэй хаяг хийсэн эсэх, хаягийн бүрэн байдал, гэрэлтүүлэг, өнгө үзэмжтэй болгосон эсэх /5 оноо/

Уралдааны үр дүнд оролцсон салбар нэгжүүд өөрсдийн оффисын өрөө тасалгаа, гадна дотор хаяг гэрэлтүүлэг, өнгө үзэмжийг сайжруулсан бөгөөд ажлын байрны эмх цэгц, ажилтнуудын бүтээмж, сэтгэлзүй, ажлын идэвхи сонирхол нэмэгдсэн байна. Мөн өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглан ажил хөнгөвчлөх, эмх цэгц сайжруулах чиглэлээр шинэ санаачлага дэвшүүлж ажилласан.

- ❖ Төв компанийн ээлжийн диспетчерийн өрөөний эмх цэгцийг сайжруулах зорилгоор горимын схемийн самбарыг шинээр байрлуулсан.
- ❖ Хуваарилах байгууламж, компанийн өрөөнүүдийн нөөц түлхүүрүүдийг ангилан өөр, өөр хайрцаг байрлуулж ангилж өлгөсөн.
- ❖ Ээлжийн монтеруудын өрөөний эмх цэгц, тохижилтонд анхаарч ажиллаж байна.
- ❖ Шуурхай үйлчилгээ мэдээллийн албаны даргын өрөөнд алдрын буланг тохижуулсан.
- ❖ Баримт бичиг цэгцлэх аяны хүрээнд баримт бичгийн хавтаснуудыг нэгж, хэсгүүд цэгцлэн хаягжуулж байршуулсан.

- ❖ Дархан-Уул аймгийн Дархан сумын 2-р хорооллын 6/0,4кВ-ын ХХбайгууламжид аюулгүй ажиллагааны плакатуудыг нэмж байрлуулсан.
- ❖ Ажилтуудын эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөнийг идэвхжүүлэх, Эрчим спортын ордны ашиглалтыг сайжруулах зорилгоор эрүүл ахуйн шаардлага хангуулан ордны доторх барилгын засварын ажлыг гүйцэтгэж ариун цэврийн өрөөний шалыг чулуун шалаар солих, ордны гадна хашааг шинээр хийх ажлуудыг тус тус гүйцэтгэсэн.
- ❖ Гагнуурчдын ажиллах нөхцлийг сайжруулж гагнуур хийх өрөөг засварлан тохижуулсан.
- ❖ Цахилгааны аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй байсан ажлын байрны байршлыг өөрчилж, шинээр ТП-99 ХХБ-ийг ашиглалтанд оруулсан.
- ❖ Компанийн төв контор, салбар нэгжүүд гадна талбайд мод тарьж, зүлэгжүүлэн ногоо байгууламжтай болгосон.
- ❖ Салбар, нэгж, хэсгүүдэд Ажлын байрны соёл – 5S-ийн хүрээнд ажилтан бүрийн хэрэглэдэг бичиг хэргийн хэрэгслийг эмх цэгцтэй болгосон.
- ❖ Зүүнхараа салбар 2018 онд 3 дэд станцыг шинэчилж 35кВ-ын дэд станцуудын хамгаалах хэрэгслэл, 0,4/6/10кВ-ын агаарын шугамын ашиглалтын заавруудыг шинэчлэн боловсруулан хянаж баталгаажуулсан, ГАУСэргийлэх анхан шатны багаж хэрэгслэл санамж плакатуудыг бүрэн болгосон.
- ❖ Хэрэглэгчийн тоолууруудыг техник ашиглалтын дүрмийн дагуу монтажлан тоолуур төвлөрсөн хайрцагуудыг будаж нэр хаяг, дугаар, аюулгүй ажиллагааны санамж, цоожийг бүрэн хийж байрлуулсан.
- ❖ 2018 онд өрөөнүүдийн ариун цэвэр эмх цэгцийн байдалд цэвэрлэгээний дотоод журам дахь асуулга бүхий хүснэгтийн дагуу сард нэг удаа шалгалт хийж тэмдэглэл хөтлөн гүйцэтгэлийн шалган ажиллаж байна.
- ❖ Гадна их цэвэрлэгээг сар бүрийн сүүлийн 7 хоног бүрийн Баасан гаригт нэгж, салбар, хэсгүүд их цэвэрлэгээ болон орчны цэвэрлэгээ хийж хэвшсэн.
- ❖ Шуурхай үйлчилгээ мэдээллийн алба 6 кВ гал хамгаалагч 53ш, 0,4 кВ 65ш гал хамгаалагч шаазангийн дотуур цэнэглэж дахин ашигладаг нь компанид 1.8 сая төгрөгний зардал хэмнэсэн.

❖ Дархан доторх 6/0,4 кВ ТП-1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 16, 17, 18,



19,
20,
21,
22,
23,
24,
25,
26,
27,

28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 37, 38, 39, 40, 41, 49, 50, 51, 59, 60, 61, 62, 63, 65,
66, 67, 69, 70 дэд станцуудын 6 кВ ХБ-ын ячейкуудын хаалгануудад шинээр нийт
223 ш цоож суулгаж хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан.



❖ 6/0,4 кВ ТП-1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 20, 22, 23, 31, 36, 62, 71 6 кВ Дэд станц, хуваарилах байгууламжийн ячейкны хаалганд аюулгүй ажиллагааны плакат тэмдэг тавих, дэд станцын диспетчерийн нэр хаяг сэргээж, сайжруулах ажлыг гүйцэтгэсэн.



❖ Компанийн гражийн гэрэлтүүлгийн монтажийг шинээр хийж, гэрэлтүүлгийг сольсон.



❖ Ажлын байранд хөдөлмөр хамгаалалын хувцас аюулгүй ажиллагааг эрхэмлэх самбар хийсэн.

❖ Ажлын үзүүлэлт дүгнэх ажилчдыг шинийг санаачлах цаг ашиглалтыг сайжруулах үзүүлэлт дүгнэж мэдээ, манлайллын самбар бий болсон.

- ❖ Хөдөлмөр хамгааллыг хэвшүүлэх тулд ажилчдын хувцас солих шкафт гарын авлагыг хийсэн



Ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөл бололцоог хангах, аюулгүй ажиллагааг хэвшил болгон ажиллах тал дээр шинэ санааг дэвшүүлж ажилчдын өрөөнд хөдөлмөр хамгааллын үзүүлэх самбарыг хийж тавьсан.



Дархан хэрэглэгчдэд үйлчлэх төвийн конторын эмх цэгцийг сайжруулсан.

Өмнө нь:



Дараа нь:



ДСЦТСХК-ийн салбар, нэгжүүд ажлын байранд 5S хөтөлбөрийг хэрэгжүүлж хэвшсэн.





6.4. ТЕХНИКИЙН БИЧИГ БАРИМТЫН ХӨТЛӨЛТ

Компанийн хэмжээнд 2018 оны 4 дүгээр сард Дэд захирал бөгөөд Ерөнхий инженерийн 2015 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн шинэчлэн баталсан “ДСЦТС ХК-ийн ХАБЭА-н дасгал сургууль явуулах, бичиг баримтыг хөтлөх журам”-ын дагуу техникийн бичиг баримтын бүрдэлт хөтлөлтөнд ИТА-үзлэг, Хөдөлмөр Хамгааллын 3-р шатны үзлэг, Захирлын зөвлөлийн гишүүдийн үзлэг, ТУЗ-ийн гишүүдийн үзлэг шалгалт хийгдэж, техникийн бичиг баримтанд хяналт тавьж, зөрчлийг арилгуулж ажиллалаа.

Компанийн хэмжээнд техникийн хөтлөгдвөл зохих 27 бичиг баримтын жагсаалтын дагуу хөтлөгдөж хэвшсэн. /Хүснэгт-1/

Д/д	Хөтлөгдвөл зохих бичиг баримтын жагсаалт	Бичиг баримтын хөтлөлт хийх ажилтан
1	Шуурхай ажиллагааны журнал	Шуурхай үйлчилгээний ажилтан, Ашиглалт борлуулалтын техникч, монтёр
2	Наряд шийдвэрийг бүртгэх журнал	
3	Захиалгын журнал	
4	Өдөр тутмын давтан зааварчилгааны журнал	
5	Тухайлсан зааварчилгааны журнал	
6	Хяналтын анхан шатны үзлэгийн журнал	
7	Гэмтлийн журнал	
8	Дуудлагын журнал	
9	Зарлан мэдээллийн журнал	
10	Аваарийн тасралтыг бүртгэх журнал	
11	Аваарийн бус тасралтыг бүртгэх журнал	
12	Цахилгаан мэдээний журнал	
13	Түлхүүр хүлээлцэх журнал	
14	Зөрчилтэй нарядыг бүртгэх журнал	
15	Схемийн зөрчлийг бүртгэх журнал	
16	Тоолуурын заалт авах журнал	
17	Ачаалын хэмжилтийг бүргэх журнал	
18	Их, урсгал засвар, эргүүл үзлэгийн график	
19	Шугам тоноглолын эргүүл үзлэгийн журнал, хуудасны бүртгэл	
20	Реле хамгаалалтын тоноглолд хийсэн ажил үйлчилгээний бүртгэлийн журнал	
21	Хэт хүчдлийн хамгаалалтын тоног төхөөрөмжид хийгдсэн ажлын бүртгэл	
22	Хэмжүүр, хэмжих хэрэгсэлд хийгдсэн ажил үйлчилгээ, энерги балансын бүртгэлийн журнал	
23	Дэд станц, хуваарилах байгууламжийн техникийн паспорт	
24	Цахилгаан дамжуулах агаарын шугамын техникийн паспорт хүчдлийн түвшин тус бүрээр	
25	Кабель шугамын техникийн паспорт	
26	0,4кВ-ын ерөнхий щит давхрын щитны техникийн паспорт	
27	0,4кВ-ын тоолуур төвлөрүүлсэн хайрцагны техникийн паспорт	



Тухайн нэгж, салбар, дэд станцад хөтлөгдөх техникийн паспортын тоо судалгааг гаргаж техникийн бичиг баримтыг хөтлөх, баяжилт хийхэд хяналт тавихад сарын эхний 7 хоногийн 1 өдөрт тогтмол ажиллахаар зохион байгуулж байна. 2018 онд хийгдсэн дээрхи үзлэг шалгалтанд 1718 ш техникийн паспорт хамрагдсан байна.

ДСЦТС ХК-ийн салбар, нэгж, хэсгийг бүрийг бичиг баримтжуулах ажлын хүрээнд Техник ашиглалтын заавар болон техникийн бичиг баримтыг 10 ширхэг хавтас бүхий гарын авлагыг хэвлэн холбогдох мэргэжилтэн ажилтнуудад тарааж өгсөн.

ДСЦТС ХК-д нийт 1718 ш техникийн паспорт хөтлөгдөж байгаагаас 0,4кВ-ын агаарын шугамын 253ш, 6кВ-ын агаарын шугамын 59ш, 10кВ-ын агаарын шугамын 60ш, 35кВ-ын агаарын шугамын 23ш, 35/10{6},{0,4}кВ-ын дэд станцын 24ш, 10,,6/0,4кВ-ын дэд станцын техникийн паспорт 472ш, Хэмжих хэрэгслийн 40ш, орон сууцны ерөнхий цитний 179ш, реле хамгаалалт автоматикийн 20ш, тоолуур төвлөрүүлсэн хайрцагны 236ш, 10,,6кВ-ын кабель шугамын 76ш, 0,4кВ-ын кабель шугам 29ш, барилгын 247ш техникийн паспорт тус тус хөтлөгдөж ээлжит болон ээлжит бус эргүүл үзлэг, урсгал засвар, их засварын тэмдэглэлийг цаг тухай бүрд нь тогтмол хөтлөн ажиллаж байна.

Компанийн хэмжээнд хөтлөгддөг техникийн паспортыг дараах хүснэгтээр үзүүлээ.

Техникийн болон барилга байгууламжийн паспортын төрөл														
	0,4кВ-ын АШ	6кВ-ын АШ	10кВ-ын АШ	35кВ-ын АШ	35/10,6,0,4кВ-ын дэд станц	6,10/0,4кВ-ын дэд станц	6кВ-ын ХХБ	ОС-ны Е/цит	ТТхайрцаг	10,,6кВ-ын КШ	0.4кВ-ын КШ	Хэмжих хэрэгсэл	Барилга	Нийт дүн
Нийт	253	59	60	23	24	472	20	179	236	76	29	40	247	1718

Компанийн салбар, хэсгүүдийг бичиг баримтжуулах ажлын хүрээнд Техник ашиглалтын заавар болон техникийн бичиг баримтыг 4 салбар, 2 төв, 3 алба, 1 хэлтэст тус тус хэвлэн холбогдох мэргэжилтэн ажилтнуудад хүлээлгэн өгсөн.



Техникийн бичиг баримтын хавтас доторхи бичиг баримтын бүрдэлтыг доорхи хүснэгтэнд үзүүллээ./Хүснэгт-3/

Д/д	Бичиг баримтын жагсаалт
1	Компанийн танилцуулга
2	ИТА-н үзлэгийн хуваарь
3	Зарчмын схем
4	Хөтлөгдвөл зохих бичиг баримт
5	Эргүүл үзлэгийн график
6	Урсгал засварын график
7	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө
8	6.10.35кВ-ын дэд станцуудын газардуулах байгууламжийн эсэргүүцлийн хэмжилт
9	35кВ-ын цэнэг шавхагчийн хэмжилт
10	Өвлийн их ачааллын хэмжилт
11	Стандартууд
12	Судалгаанууд

Техник ашиглалтын зааврыг тус компанид шинээр нэвтрэн орсон ухаалаг тоолуур, гүйдлийн трансформатор тоолуур шалгадаг эталон төхөөрөмж, 35кВ болон 6, 10кВ-ын сүлжээнд ашиглалтанд орж байгаа 2-догч болон анхдагч хэлхээний угсралт ашиглалтын зааврууд мөн галын аюулгүй байдал, тухайн тоноглолтой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны заавруудыг нэмж тусган 2018 оны 12 дугаар сард хэсэг тус бүрийн ашиглалт засварын техникч, монтёруудад 6 бүлэг болгон стандартын дагуу шинэчлэх ажил зохион байгуулна.

Энэ нь тухайн салбар хэсгийн техникч, монтёрууд ээлжит болон ээлжит бус техник ашиглалтын дүрэм болон цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны шалгалт өгөхөд илүү ойлгомжтой товхимол болж чадсан гэж үзэж байна.


Техник ашиглалтын зааврыг 6 бүлэг болгон хэвлэсэн товчоог доорхи хүснэгтээр үзүүлье. /Хүснэгт-4/

Д/д	Ашиглалтын зааврын бүлэг жагсаалт
1	Тасалж залгах аппаратуруудын ашиглалтын заавар
2	Гүйдэл хүчдлийн трансформатор болон релений ашиглалтын заавар
3	Газардуулгын байгууламж, Хуваарилах байгууламж, Мегометр, Цэнэг шавхагчуудын ашиглалтын заавар
4	Тоолуур шалгадаг эталон төхөөрөмж болон тоолууруудын ашиглалтын заавар
5	Цахилгаан дамжуулах агаарын шугамын ашиглалтын заавар
6	Цахилгаан дамжуулах кабель шугам, гэмтэл тодорхойлох багажны ашиглалтын заавар

2017 онд “ТЕХНИК АШИГЛАЛТ, БҮРТГЭЛ ТООЦООНЫ ПРОГРАМ” шинээр хийж ашиглаж эхэлсэн нь техникийн бичиг баримтыг цахим бүртгэлд оруулж архивлах боломжтой болсон. Програм ашиглалтанд орсноор бичиг баримтыг хөтлөлтөөс гадна их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт, урсгал засвар, эргүүл үзлэг, шийдвэр, наряд, тухайн ажилд зарцуулах шатахууны төлөвлөгөө, төсөв хийх, гүйцэтгэл акт гаргах, зардал хянах зэрэг шаардлагатай үедээ хүссэн тайлангаа татаж авдаг болсоноор ажлыг төлөвлөгөөт хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх, хийсэн ажлын тайланг тухайн тоноглолын техникийн паспортанд давхар бүртгэх зэрэг давуу талууд бий болсон.

Програмд нэвтрэх хэсэг

Microsoft Internet Explorer

 **ТЕХНИК АШИГЛАЛТЫН ПРОГРАМ**
Техник бодлого төлөвлөлтийн хэлтэс

Цахилгаан түгээх сүлжээний
техник ашиглалтын програм 1.0 MNG

Сервер 192.168.1.89 ... Хэрэглэгч Admin
Бааз Dsedn2016 ... Түлхүүр үг

Програм шинэчлэх **Нэвтрэх** **Гарах**

www.presoft.mn © 2007 - 2016 Прософт ХХК

Аюулгүй ажиллагааны наряд, шийдвэрээр хийсэн ажил оруулах хэсэг

Аюулгүй ажиллагааны наряд

Аюулгүй ажиллагааны наряд | Засах горим

Салбар/албе: 23 | Огноо: 2016.05.18
 Засварын ажил: 2016-11 | Дугаар: Туршилт-1

Ажил: Туршилт-1 Их засварын ажилын 1-р шатны ажилд явсан хүмүүсийн мэдээлэл

Наряд олгосон: 31000 | Эхлэх огноо: 2016.05.18 | Эхлэх цаг: 09:00
 Олгосон огноо: 2016.05.20 | Олгосон цаг: 15:32 | Дуусах огноо: 2016.05.20 | Дуусах цаг: 09:00

Тусгай заалт:

Бригадын бүрэлдэхүүн | Ажлын байр баятгах арга хэмжээ

Код	Ажилтны нэр	Зэрэг	Код	Үүрэг	Т.сэрд.Аж.цаг	Д.сэрд.Аж.цаг
31424	Гантулга-Мянгарсүрэн	1.00	03	Ажлын хариуцлагатай гүйцэтгэгч	10.00	
31426	Сандаг-Очирбаатар	1.00	05	Бригадын бүрэлдэхүүн	5.00	
31512	Чинзориг-Эрдэнэбат	1.00	05	Бригадын бүрэлдэхүүн	10.00	
31535	Энхболд-Эрдэнэбилэг	1.00	01	Ажлын удирдагч	10.00	

Эхний дүгээр хэсгийн системийн гүйцэтгэл / хураангуй

№	Төрөл	Тайлбар	Т.сэрд.Аж.цаг	Д.сэрд.Аж.цаг
1	Төрийн захирлын үйлдвэр
2	Төрийн захирлын үйлдвэр
3	Төрийн захирлын үйлдвэр
4	Төрийн захирлын үйлдвэр
5	Төрийн захирлын үйлдвэр

Microsoft Excel



файл Лавлах Техникийн паспорт Их засвар Урсгал засвар Нарядын бүртгэл Тайлан Цонх

Шийдвэрээр хийсэн ажлын жагсаалт

Огноо: 2016.05.01 -- 2016.05.31

Дугаар	Их засвар	Код	Ажилтан	Ажлын үүрэг	Т.Сэрд.Аж...	Д.Сэрд.Аж...	Ажлын агуулга
23	Санхүү Эдийн Засгийн хэлтэс	31002	Батжаргал	Ажлын цаг	120.00	25.00	
211	Зохиргаа удирдлагын хэлтэс	31006	Ч.Энхболд	01	120.00	0.00	hgyggjhlkghkgh
211	Зохиргаа удирдлагын хэлтэс	31003	Баярхүү	01	120.00	0.00	hgyggjhlkghkgh
211	Зохиргаа удирдлагын хэлтэс	31006	Б.Алтанхуяг	02	120.00	0.00	hgyggjhlkghkgh

2018 онд техник, ашиглалтын програмд нэмж тасралт, залгалт, техникийн нөхцлийн нэмэлт бүлэг оруулсан. Ингэснээр тасралт, залгалтын ангилал, сайди, сайфи, кайди үзүүлэлтүүдийг програм дээрээс шууд гаргах боломжтой болсон.





ДСЦТС ХК
Захиалагаар хийгдсэн

Д/д	ХБ тоноглогчийн нэр	Хүчдэл	Цэвэрлэлт	Төсөрсөн	Залгаан	Үргэлжилсэн	ДТЦОХ	Тасалгаа	Арсан арга хэмжээ	
1	110650 Давхар дэд станцийн	0.00		2017.11.03 10.22	2017.11.03 10.23		7.85	293.88	Гүйцэтгэсэн	ТТ-66 өмчлөгчид ДСЦТС-ийн төхирөө ажил хураард зөвлөсөн
2	Борнуур АТП-1193-66 АШ	0.40	173.00	2017.11.03 11.06	2017.11.03 10.19		4.22	163.59	Ижтэй	0.4кВ АШ-д 31 пролет сийр-26 утас таслан
3	Төмөр тээврийн	0.00		2017.10.01 11.20	2017.10.01 10.05		5.26			Худал 6кВ Бэлтгэл АШ-н утас таслан
4	РП-10 ХЭВНЧ-9 АШ	0.00	87.00	2017.11.01 12.25	2017.11.01 10.10		5.78		Гүйцэтгэсэн	8кВ тугуур болсон ТТ-66 өмчлөгчид өндөр чиглээр турьсан ТТ-66 835 м-ийг таслан
5	Худал 6кВ АШ ЯМ-2	0.00	87.00	2017.11.01 09.05	2017.11.01 10.29		8.90		Ижтэй	АШ-д 3 ш тугуур болсон
6	Хэрэглэгчид 6кВ АШ-10	0.40	78.00	2017.11.01 10.05	2017.11.01 10.20		0.83		Салсан-залгалт	Тр-д 30 л-ос болсон
7	АТП-101 0.4кВ АШ			2017.11.01 09.19	2017.11.01 09.19				ТЭБХХ	
8	АТП-148 0.4кВ АШ			2017.11.01 09.19	2017.11.22 09.19				ТЭБХХ	
9	АТП-150 0.4кВ АШ			2017.11.01 09.19	2017.11.22 09.19				ТЭБХХ	
10				2017.11.27 10.31	2017.11.27 10.31				Хөрөнгө зориулалт	
11	АТП-103 0.4кВ АШ	0.40	68.00	2017.12.01 11.25	2017.12.01 12.27		1.12		Гүйцэтгэсэн	0.4кВ АШ-д ТТ-10 болсон
12	АТП-105 0.4кВ АШ	0.40	23.00	2017.12.01 10.42	2017.12.01 12.09		1.38			иргэн Гундэмтэгийн 0.22кВ тугуур болсон
13	АТП-108	0.40	247.00	2017.12.01 12.18	2017.12.01 12.03		0.82		Гүйцэтгэсэн	0.4кВ шилдэг албагчид өмчлөгчид В-фазын шинэ хайлсан гүйцэтгэсэн
14	Зүүн бүрэн дэд станц ЯМ-10 I	10.00	4.00	2017.12.01 10.16	2017.12.01 10.05		7.50			ТТ-104 болсон, ТТ-104-105 хооронд В-С фазын утас болсон
15	Зүүн бүрэн дэд станц ЯМ-10 I	10.00	4.00	2017.12.01 11.25	2017.12.01 10.05		7.26			АШ-д тасвар хийсэн
16	Зүүн бүрэн дэд станц ЯМ-10 I	10.00	4.00	2017.12.01 10.25	2017.12.01 10.20		8.08			АШ-д тасвар хийсэн
17	Аж Ахуйн хэвцэр барих явцад			2017.12.27 09.05	2017.12.27 09.05					
18	Зөвхөн хийгдсэн			2017.12.27 09.05	2017.12.27 09.05					
Нийт дүн:			783.00				59.76	467.27		

6.5. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 20-ний өдрийн 274 дүгээр тогтоолоор Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр батлагдсаны дагуу ДСЦТСХК-ийн 2018-2022 онд хэрэгжүүлэх 6 бүлэгтэй “Эрчим хүч хэмнэх хөтөлбөр”-ийг батлуулан хэрэгжүүлж байна.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2018 оны Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөний биелэлт 100 %-ийн гүйцэтгэлтэй байна.

Хөтөлбөрийн зорилго нь Эрчим хүчний хэмнэлт, байгаль орчныг хамгаалахын тулд эрчим хүчний шугам сүлжээний түгээлтийн алдагдал, барилга байгууламжийн өөрийн хэрэгцээний цахилгаан зарцуулалт, дулааны алдагдлыг бууруулах, эх үүсвэрийн дутагдалд орохоос сэргийлэх, үйлдвэрлэгчийн ялгаруулах хүлэмжийн хийг бууруулахад оршино. Үүнд:

- 1) Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, нөхцөл байдал, хамрах хүрээ
- 2) Зорилго, зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх арга зам
- 3) Хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа
- 4) Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт
- 5) Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр
- 6) Хяналт шинжилгээ, үнэлгээ

“Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”-ийн 3-р бүлгийн 10.2.2-р зүйлд заасан Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн үүргийн дагуу компанийн эрчим хүчний аудитыг “ Шинэ



эрчим инженеринг ХХК-тай Эрчим хүчний аудит хийх гэрээ байгуулан ажиллаж аудитын тайланг хүлээж авсан.

Эрчим хүчний аудитын тайлан нь аудитын тайлангийн хураангуй, аудит хийсэн хууль эрх зүйн үндэслэл, аудитын үйл ажиллагаа ба үр дүн, эрчим хүчний аудитын тайлан гэсэн 4 бүлгээс бүрдэж байна.

Эрчим хүчний аудитын тайланд дараах чиглэлүүдээр эрчим хүч хэмнэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр тодорхой эрчим хүчний хэмнэлт гарах боломжтой гэсэн дүгнэлт зөвлөмжийг гаргасан. Үүнд:

	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гарах үр дүн	Хөрөнгө оруулалт
ДСЦТС ХК 35кВ дэд станцууд	Хөрөнгө оруулалтын зардал өндөртэй тул эхний ээлжинд тодорхой арга хэмжээ төлөвлөөгүй.		
ДСЦТС ХК 6,10кВ дэд станцууд	Трансформаторуудыг ачаалалд тохируулж солих, сэлгэх хөтөлбөр хэрэгжүүлэх Шинээр эрчим хүчний хэмнэлттэй трансформаторууд худалдан авах	Жилийн дүнгээр 791.8 мян.кВт.ц цахилгаан эрчим хүч хэмнэнэ.	Нэг трансформатор солих зардлыг 150 мян.төг, нийт зардал 38.2 сая. төгрөг
ДСЦТС ХК 6,10 кВ-ын сүлжээ	Шугамын техникийн алдагдал 8%-аас дээш 30 фидерийн судалгаа хийж, алдагдал бууруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх	Жилд дунджаар 1.4 сая.кВт.ц цахилгаан эрчим хүч хэмнэх боломжтой	Хөрөнгө оруулалтыг тухайн үед нарийвчилж тооцох
ДСЦТС ХК 0.4 кВ-ын сүлжээ	100 дэд станцын 0.4кВ-ын сүлжээг СИП дамжуулагчаар шинэчилж, хэрэглэгчийн тоолуурыг төвлөрүүлж ухаалаг тоолуур суурилуулах төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж дуусгах	Жилд дунджаар 6.8 сая.кВт.ц цахилгаан эрчим хүч хэмнэх боломжтой	Нийт 300 км нам хүчдлийн сүлжээг шинэчлэхэд 6.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай
ДСЦТС ХК цахилгаан борлуулалт	Бүх хэрэглэгчдийг ухаалаг тоолуурын системд холбох, борлуулалтын хяналтыг системийг нэвтрүүлэх	Арилжааны алдагдлыг жилд 5.6 сая кВт.ц-аар, төсөл бүрэн хэрэгжсний дараа 16.7 сая.кВт.ц-аар буурна.	Нийт 34840 ухаалаг тоолуур суурилуулахад 8.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай
ДСЦТС ХК өөрийн хэрэглээ	Температурын тохируулгатай халаагуур хэрэгтэх, эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг хэрэглэх, дулааны тоолууржуулалт хийх, парк шинэчлэлт хийх	Жилд дунджаар 268.8 мян.кВт цахилгаан, 193Гкал дулаан, 43.6 тн бензин, түлш хэмнэх боломжтой	Нийт 46.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт
ДҮН		Цахилгаан 14860.6 мян.кВт.ц Дулаан 193.0 Гкал Түлш 43.6 Тн	14.98 тэрбум төгрөг

Ингэснээр байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь нийт дүнгээр 14860.6 мян.кВт.ц цахилгаан, 193Гкал дулааны эрчим хүч, 46.3 тн шатахуун хэмнэснээр 9787.7 тн бодит нүүрс, агаар мандалд хаягдах хүлэмжийн хийг 13913.7 тн-оор бууруулна.




	Хэмнэх эрчим хүч	Жишмэл түлшний хэмнэлт/бууралт	Хэмнэх бодит түлш /тн/	Хүлэмжийн хийн бууралт
ДСЦТС ХК 6,10кВ дэд станцууд	791.8 мян.кВт.ц	251.2 тн	510.4 тн	725.62 тн
ДСЦТС ХК 6,10 кВ-ын сүлжээ	1.4 сая.кВт.ц	444.2 тн	902.5 тн	1282.99 тн
ДСЦТС ХК 0.4 кВ-ын сүлжээ	6.8 сая.кВт.ц	2157.6 тн	4383.7 тн	6231.65 тн
ДСЦТС ХК арилжааны алдагдал	5.6 сая кВт.ц	1776.84 тн	3610.1 тн	5131.95 тн
ДСЦТС ХК өөрийн хэрэглээ	268.8 мян.кВт.ц	85.29 тн	173.3 тн	246.33 тн
	193.0 Гкал	33.9 тн	68.9 тн	97.91 тн
	43.6 тн түлш	68.3 тн	138.8 тн	197.27 тн
ДҮН	Цахилгаан 14860.6 мян.кВ Дулаан 193.0 Гкал Түлш 43.6 Тн	4854.61 тн	9787.7 тн	13913.72 тн

Эрчим хүчний аудит, эрчим хүч хэмнэх хөтөлбөрийг хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн:


1. *Байгальд ээлтэй, үр ашигтай дэвшилтэд техник технологи, инноваци болох УХААЛАГ ТООЛУУРЫН СИСТЕМ-г үргэлжлүүлэн хөгжүүлж өргөжүүлэн арилжааны алдагдлыг бууруулах;*

Компани ЦЭХ-ний түгээлтийн алдагдлыг бууруулахаар ухаалаг тоолуурын системийг 2013 оноос эхлэн нэвтрүүлж 2018 оны эхний 10 сарын дүнгээр ахуйн хэрэглэгчдийн 73% хувь буюу 34516 хэрэглэгчид ухаалаг тоолуурыг суурилуулж борлуулалт арилжааны системд холбосон.

Ухаалаг тоолуур суурилуулж эхэлсэн 2013-2018 онд 10/6/0,4кВ-ын сүлжээний дүнгээр ЦЭХ-ний түгээлтийн алдагдал 16,5 сая кВт цаг буюу 7,9 пунктээр буурсан байна.



10/6/0,4кВ-ын сүлжээний дүнгээр ахуйн хэрэглэгчийн ЦЭХ-ний авлага 381,9 сая төгрөг буюу 73,7 хувиар буурсан.



2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 10/6/0,4кВ-ын сүлжээний алдагдал өмнөх оны мөн үеэс 5,2 сая кВт буюу 2,8 пунктээр бууруулж байна.


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 он	2018 оны ХБГ	Алдагдлын бууралт	
Худалдан авсан ЦЭХ	сая кВтц	204.5	207.2	2.7	
Борлуулсан ЦЭХ	сая кВтц	164.2	172.0	7.9	
ЦЭХ-ний алдагдал	биет	сая кВтц	40.3	35.1	-5.2
	хувь	%	19.7%	17.0%	-2.8%

Алдагдлын бууралтыг хүлэмжийн хийд шилжүүлж тооцвол 1649,9тн жишмэл түлш, 3352,1тн бодит түлш, 4765,4тн хүлэмжийн хий бууруулсан.


Он	Бууруулсан алдагдал /сая кВт цаг/	Жишмэл түлшний хэмнэлт /тн/	Хэмнэх бодит түлш/тн/	Хүлэмжийн хийн бууралт /тн/
2018	5.2	1649.9	3352.1	4765.4

ЦЭХ-ний түгээлтийн алдагдал бууруулахаар авч хэрэгжүүлсэн ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлж эхэлсэн 2013 оныг суурь он болгож 2018 он хүртэл хэмнэгдсэн ЦЭХ-ийг тооцвол 5 жилийн хугацаанд 44,2 сая кВт цаг хэмнэгдэж 6,9 тэр бум төгрөгний борлуулалтын орлого буюу үр ашиг нэмэгдсэн байна.

2013-2018 онд Хэмнэсэн ЦЭХ /сая кВт цаг/



2013-2018 онд Хэмнэсэн ЦЭХ / сая төгрөг/




2. Цахилгаан байгууламж, цахилгаан тоног төхөөрөмжийг олон улсын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр солих, нам хүчдэлийн агаарын шугамын дамжуулагчийг СИП кабелиар сольж техникийн алдагдлыг бууруулах;

ТМ маркийн трансформаторыг ОХУ-ын Электрозавод үйлдвэрийн ТМГ-У1 маркийн 61 хүчний трансформатороор сольж тавьсан. Ингэснээр трансформаторын зүрхэвч дээр алдагдах алдагдал 5200 кВт цагаар буурч жилд хэмнэх цахилгааны зардал 9,2 сая төгрөгөөр хэмнэгдэнэ. Мөн тоолуур төвлөрүүлсэн 0,4кВ-ын ЦДАШ-г СИП кабелиар сольсон. Мөн 35кВ, 6кВ-ын вакуум таслууртай ХБ-уудын дотоод хэрэгцээний трансформаторуудыг байгальд ээлтэй тосгүй бага чадлын 5 ширхэг АВВ –ийн хуурай трансформатораар сольсон.



3. Цахилгаан байгууламжийн болон оффисийн дулааны алдагдлыг бууруулах, дотоод хэрэгцээний халаагуур, гэрэлтүүлгийг солих замаар дотоод хэрэгцээний цахилгаан зарцуулалтыг багасгах;

Дэд станцууд дээрх хуучин 3,5кВт түүнээс дээш чадалтай хар халаагуурыг тохируулагчтай 2,2 кВт-ын тохируулагчтай халаагуураар 18 ширхэгийг сольсноор 59,4 сая кВт цаг ЦЭХ хэмнэгдэж 9,2 сая төгрөгөөр зардал хэмнэгдсэн.



№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнө /хар халаагуур/	Дараа /Тохируулагчтай халаагуур/
1	Халаагуурын тоо	ш	18	18
2	Чадал	кВт	3.5	2.5
3	Жилд ажиллах цаг	цаг	1800	1200
4	Жилд хэрэглэх цахилгаан	мян.кВт.ц	113.4	54.0
5	Цахилгааны үнэ	төг/кВт.ц	154.4	154.4
6	Цахилгааны төлбөр	мян.төг	17511.0	8338.6
	Хэмнэлт жилд	мян.кВт.ц		-59.4
		мян.төг		-9172.4
	Халаагуурын үнэ	мян.төг		4818.2
	Өртөгөө нөхөх хугацаа	жил		0.5

Авто машины гажийн 400Вт-ын улайсах чийдэнг гэрлийн урсгал илүү эрчим хүчний хэмнэлттэй 300Вт-LED гэрлээр мөн компанийн төв контор, 6 кВ-ын РП-нүүд, Дархан хэрэглэгчдэд үйлчлэх төвийн 144Вт-ын таазны гэрэлтүүлгийг 55Вт-ын Солонгос улсад үйлдвэрлэгдсэн Нирро маркийн гэрэлтүүлэгээр сольсноор жилд 27,4 мян кВт цаг буюу 3,8 сая төгрөгөөр хэмнэсэн байна.



№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнө /хар халаагуур/	Дараа /Тохируулагчтай халаагуур/
1	Халаагуурын тоо	ш	18	18
2	Чадал	кВт	3.5	2.5
3	Жилд ажиллах цаг	цаг	1800	1200
4	Жилд хэрэглэх цахилгаан	мян.кВт.ц	113.4	54.0
5	Цахилгааны үнэ	төг/кВт.ц	154.4	154.4
6	Цахилгааны төлбөр	мян.төг	17511.0	8338.6
	Хэмнэлт жилд	мян.кВт.ц		-59.4
		мян.төг		-9172.4
	Халаагуурын үнэ	мян.төг		4818.2
	Өртгөө нөхөх хугацаа	жил		0.5

4. ЦДАШ-н тулгуурт модон тулгуурын хэрэглээг багасгаж төмөр бетон тулгуур хэрэглэж нийлүүлэгдэж байгаа хүчилтөрөгчийн хэмжээг бууруулахгүй байх

Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажилд модон тулгуур ашиглахаас татгалзаж 2018 онд 35кВ-ын сүлжээнд-137ш, 10кВ-ын сүлжээнд 828ш, 0,4кВ-ын сүлжээнд 3466ш, нийт 1 тэрбум 671 сая төгрөгийн өртөг бүхий 4431ш бетон тулгуур ашигласан. Энэ нь жилд 4431ш ургаа шилмүүст мод огтлогдохоос урьдчилан сэргийлсэн байна. Цахилгаан дамжуулах агаарын шугамын модон тулгуур 6-8 жил, төмөр бетон тулгуур 25 жил ашиглагддаг гээд үзвэл 2018 онд худалдан авсан 1

тэрбум 671 сая төгрөгийн үнэ бүхий төмөр бетон тулгуур ашигласан нь 15199 ш ургаа мод огтлогдохоос урьдчилан сэргийлсэн байна.



5. Эрчим хүчийг хэмнэхэд цахилгаан эрчим хүч хэрэглэгчид эрчим хүчний үнэ цэнэ, хэмнэлт хийх боломж, хэмнэлт хийснээр гарах үр дүнгийн талаар мэдээлэл өгөх, сургалт явуулах;

5.1 Эрчим хүний хэмнэлтийн чиглэлээр 19 байгууллагын 1110 хүнд сургалт явуулж, 4 шторк, 6000ш брошур, 1500ш гарын авлага тарааж, 4 удаа ярилцлагыг телевиз, хэвлэлээр явуулсан. Үүнд: Эрчим хүчний хэмнэлтийн тухай ойлголт, хууль эрх зүйн орчин, эрчим хүч хэмнэх боломж, арга хэрэгслүүдийн талаар компанийн ажилтнуудад мэдлэг олгох зорилгоор компанийн салбар нэгжүүдийн 310 ажилтнуудад сургалт мэдээллийг явуулсан.



Дээрхи сургалтын агуулагад эрчим хүчийг хэмнэх шалтгаан нь байгаль орчины хүлэмжийн хийг бууруулах, нөхөн сэргээгдэхгүй нөөцийг ариг гамтай хэрэглэж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах талаар мэдээлэл зөвлөмж багтсан.



5.2 Мөн 2018 оныг Эрчим хүчний хэмнэлт үр ашгийн жил болгон зарласантай холбогдуулан компанийн ажилтнуудыг хэмнэлтийн үйл ажиллагаанд идэвхижүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах сэтгэл зүйд хандуулах зорилгоор тайлант хугацаанд “Эрчим хүний хэмнэлт” гар зургийн уралдааныг нийт ажилтнуудын дунд зарлаж 7 ажилтныг шалгаруулан урамшууллаа. Уралдаанд ирүүлсэн бүтээлээс...



Хэрэглэгчдэд зориулсан Эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглэх, байгаль дэлхийгээ хайрлах талаар зөвлөмж шторк хийж орон нутгийн телевиз, мэдээлэлийн сувгуудаар явуулж байна.



Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай зарцуулах чиглэлээр сургалт сурталчилгаа хийх ажлын хүрээнд ЦЭХ, ус, ой мод цаасаа хэмнэх хэмнэлтийн талаар брошур хийж, компанийн бүх ажлын байранд тавьсан.



ЭХЯам, ЭХЗХороо, Хэмнэлтийн зөвлөл, Хас банктай хамтран “Шинэ техник, технологи ба үр ашиг”, “Ногоон технологи, Эрчим хүчний хэмнэлт-2018”, “Ногоон санхүүжилт” зэрэг уулзалт, зөвлөгөөнд мэдээлэл хийсэн.



6. Эрчим хүч хэмнэлтийн хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх

Эрчим хүчний хэмнэлтийн 2, сэргээгдэх эрчим хүчний 1 инженерийг сургаж, мэргэшүүлсэн.

Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр БНХАУ-ын Бээжин, Япон улсын Нагояа, Шизүка хотуудад 14-45 хоногийн сургалтанд 6 инженер, МХАҮТ-ын “**Байгаль орчны Менежментийн систем**”-ийн 4 инженерийг багшаар сургасан.



Дархан-Уул аймгийн Хонгор суманд 20МВт-ын нарны цахилгаан станцыг барих төсөл хэрэгжүүлэхээр Японы "Шарп" корпорацитай Хамтын ажиллагааны гэрээ байгуулж, үйлдвэрийн шав тавьсан. Төсөл хэрэгжснээр жилд дунджаар 32.0 сая.кВт.ц ЦЭХ нийлүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг жилд 25505 тонноор бууруулж, 355 сая литр усыг хэмнэнэ. Угсралтын явцад 200 түр, 20 байнгын ажлын байр бий болно.

ДҮГНЭЛТ

2018 онд нэг худалдан авагчаас 443.6 сая кВт цаг цахилгаан эрчим хүч /ЦЭХ/ худалдан авахаар төлөвлөснөөс 437.4 сая кВт цаг ЦЭХ авч 6.2 сая кВт цагаар буурсан. Энэ бууралт нь Аж ахуйн харилцааны дүрэмд заасан (+2%) хэмжээнд байна.

Компанийн дүнгээр цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал 61,2 сая кВт цаг буюу 13,98 хувь болж төлөвлөгөөт 14,80 хувийн алдагдлыг 0.82 пунктээр бууруулж, Эрчим хүчний Зохицуулах хорооноос баталж өгсөн зорилтыг ханган ажиллалаа.

Гүйцэтгэлд Ногдох Төлөвлөгөөгөөр 2018 онд 372,7 сая.кВт.ц ЦЭХ борлуулахаас 376,2 сая кВт цаг эрчим хүч борлуулж, борлуулалтын төлөвлөгөө 100,9 хувиар биелсэн.

Компанийн ЦЭХ-ний хэрэглээний дотоод хэрэгцээг өмнөх оны мөн үеэс 103,6 мян кВт цаг буюу 11,3 сая төгрөгөөр буурч 5,3 хувиар хэмнэсэн.

Ухаалаг тоолуур суурилуулсан 10/6/0,4кВ-ын сүлжээний алдагдал өмнөх оны мөн үеэс 5,2 сая кВт буюу 2,8 пунктээр буурсан.

Тайлант хугацаанд 75.0 тэрбум төгрөгийн орлоготой, 74.5 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, татвар төлөхийн өмнөх дүнгээр 482.3 сая төгрөгийн ашигтай ажиллалаа.



Их засвар, ТЗБАХ, ХО-ын 38 ажлыг 4,9 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 41 ажлыг хийж 4,9 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.

Эргүүл үзлэг- 8876 цэгт эргүүл үзлэг хийхээр төлөвлөж 8876 цэгт хийж 773 гэмтлийг илрүүлж ашиглалтын хэвийн ажиллагааг ханган ажилласан. Хэрэглэгчдээс 35002 дуудлага ирснийг барагдуулсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 14897 буюу 30%-иар буурсан. Дуудлага барагдуулалтын дундаж хугацаа 2017 онд 34,3 минут байсан бол 2018 онд 29 минут болж буурсан.

Гэмтэл- 163 гэмтэл гарсан нь өмнөх оныхоос 25 гэмтлээр буурсан.

Трансформаторын гэмтэл 5-р буурсан бөгөөд нийт 43 хүчний трансформаторт засвар, үйлчилгээ хийж ашиглалтанд шилжүүлсэн.

Ашиглалтын түвшин- ИТА-ын үзлэгээр ашиглалтын түвшинг тогтооход 86,9% болж өмнөх оныхоос 3,8 нэгжээр өссөн. Дэд станцуудын ашиглалтын түвшин сайжирч, 0,4кВ-ын агаарын шугамын шинэчлэлийн ажил хийгдсэнээр дуудлагын тоо буурч байна.

Ажлын зураг- 38 иж бүрэн томоохон ажлын зургийг гүйцэтгэсэн. 71км урт 0,4кВ-ын агаарын шугамын зураг, 2км 6кВ-ын агарын шугамын, 1,69км Кабель шугам, 20км 35кВ-ын агаарын шугамын зураг хийж гүйцэтгэсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Мандал, Сүхбаатар, Хүдэр, Шаамар сумын гэр хорооллын шугамын шинэчлэлийн зураг хийгдсэн.

Техникийн нөхцөл олголтоор 451 хэрэглэгчид холболтын зөвшөөрөл олгож иргэд аж ахуйн нэгжийн цахилгаан хангамжийг шийдвэрлэсэн.

Шинэ техник технологи нэвтрүүлэх ажлаар 6/0,4кВ-ын дэд өртөөг аюулгүй байдлыг бүрэн хангасан Герман технологи ашигласан.

2018 онд ISO45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, нарыдаар шийдвэрээр гүйцэтгэх 6313 ажлыг хянаж, аюулгүй ажиллагааны зааварчилгаанд давхардсан тоогоор 52825 ажилтныг хамрууллаа.

Эрчим хүчний яамнаас ДСЦТСХК-ийн шалгалтын комисс, шуурхай ажиллагааны ажилтнуудаас авсан шалгалтанд 89.2%-ийн амжилт үзүүллээ.



Компанийн ажилтан ажилчдыг ажлын тусгай хувцас гутал, хамгаалах хэрэгслээр хангах зардалд 287,3 сая төгрөг, галын аюулаас урьдчилан сэргийлэх зардалд 2.1 сая төгрөг буюу нийт 289,4 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэл ХАБЭА-н зардал 305,7 сая төгрөг, галын аюулаас урьдчилан сэргийлэх 40,1 сая төгрөгийг тус тус зарцуулж, нийт 345,8 сая төгрөгийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ГАУС-ын зардалд зарцууллаа.

Мөн Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал ISO45001:2018 менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд 60,7 сая төгрөгийн Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, сургалтанд 10,8 сая төгрөг нийт 71,5 сая төгрөгийг зарцуулсан.

ХАБЭА-н анхан болон II шатны үзлэгийг 5545 удаа хийж, ажилтан нэг бүрийг ажлын байранд сургаж хөгжүүллээ.

Дээрхи 10/6/0,4кВ-ын сүлжээний алдагдлын бууралтыг хүлэмжийн хийд шилжүүлж тооцвол 1649,9тн жишмэл түлш, 3352,1тн бодит түлш, 4765,4тн хүлэмжийн хий бууруулсан байна.

Эрчим хүч хэмнэлтийн хууль тогтоомжийг суртачилах, Эрчим хүч хэмнэх, байгаль дэлхийг хайрлах, хүлэмжийн хийг бууруулах, байгалийн нөөцийг гамнахад хувь нэмэрээ оруулах зөвлөмжийг 19 байгууллагын 1110 хүн, компанийн 310 ажилтанд сургалт явуулж, 4 шторк, 6000ш брошур, 1500ш гарын авлага тарааж, 4 удаа ярилцлагыг телевиз, хэвлэлээр явуулсан.

2018 онд “НЭН ТҮРҮҮНД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ” зарчимд тулгуурлан осол зөрчилгүй ажиллалаа.

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК